**БУЛГАН АЙМГИЙН СОЁЛ УРЛАГ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ГАЗРЫН**
**2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

| Д/Д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв /Сая ₮/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ** | | | | | | | |
| ***1.1 Соёлын байгууллагуудын барилга байгууламжийг нэмэгдүүлэх, техник хэрэгслийн хангамжийг сайжруулах*** | | | | | | | |
| 1.1.1 | Бугат сумын Соёлын төвийн шинэ барилгын ажлыг дуусгах | УТ 464.62 | Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь | 2023 онд 200 сая төгрөгийн ажил хийгдсэн. | Барилгын ажил дуусаж ашиглалтад оруулсан байна. | 2024 оны төсөвт тусгагдсан 464.2 сая төгрөгийн барилгын ажлыг бүрэн гүйцэтгэж барилгын гадна фасадын ажлыг дуусгасан. Дотор заслын ажил хийгдэж байна. | 90% |
| 1.1.2 | Аймгийн Нийтийн номын сангийн шинэ барилгын ажлыг эхлүүлэх | УТ 1535.10 | Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь | Зураг төсөв хийгдсэн. | Гүйцэтгэгчийг шалгаруулж барилгын ажлыг эхлүүлэн 50 хувьд хүргэнэ. | "Зууны Сод Хийц" ХХК гүйцэтгэгчээр шалгарч барилгын гадна болон дотор засал, цахилгаан, дулааныг хийж дуусгасан. Улсын комисст хүлээлгэн өгөхөөр хүсэлтээ өгөөд байна. | 100% |
| 1.1.3 | Бүрэгхангай сумын соёлын төвийн шинэ барилгын ажлыг эхлүүлэх | УТ 1149.57 | Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь | Зураг төсөв хийгдсэн. | Гүйцэтгэгчийг шалгаруулж барилгын ажлыг эхлүүлэн 30 хувьд хүргэнэ. | Барилгын ажлын гүйцэтгэгчээр “Сод Эрдэнэ Алтай” ХХК шалгарч хуучин барилгыг нурааж зөөсөн. Шинэ барилгын суурийн ажлыг эхлүүлсэн. | 70% |
| 1.1.4 | Соёлын байгууллагад техник хэрэгсэл нийлүүлэх | УТ 153.0 сая төгрөг | Техник хэрэгсэл нийлүүлэгдсэн эсэх | 2023 онд 50 сая төгрөгөөр техник хэрэгсэл авч өгсөн. | Гэрээ хийж хүлээн авч соёлын байгууллагуудад нийлүүлсэн байна. | Соёл урлагийн байгууллагын техник хэрэгсэл, материалыг үе шаттай шинэчлэх зорилгоор орон нутгийн төсвийн 260.4 сая төгрөгөөр 6 сумын Соёлын төвд Лед дэлгэц, ОНТ-н 155.1 сая төгрөгөөр тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, Улсын төсвийн 808.1 сая төгрөгөөр техник хэрэгслийн шинэчлэл хийсэн. | 100% |
| 1.1.5 | Соёлын үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгоор автомашиныг шийдвэрлэх | ОНТ 50,0 сая төгрөг | Автомашин нийлүүлэгдсэн эсэх | - | Булган сумын Соёлын ордонд автомашин нийлүүлсэн байна. | Булган сумын Соёлын ордонд Альфард маркийн авто машиныг орон нутгийн төсвөөс шийдвэрлүүлж хүлээлгэн өгсөн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.1.6 | Орхон сумын соёлын төвийн барилгын их засвар | ОНТ 450.0 сая төгрөг | Их засварын ажлын гүйцэтгэл | - | Их засварыг гүйцэтгүүлж ашиглалтад хүлээн авна. | Гүйцэтгэгчээр "Гурван Улын Хишиг" ХХК шалгарч засварын ажлыг бүрэн хийж ашиглалтад хүлээлгэн өгсөн. | 100% |
| 1.1.7 | Аймгийн Музейн барилгын их засвар | ОНТ 200.0 | Их засварын ажлын гүйцэтгэл | 2023 онд 120 сая төгрөгийн засвар хийгдсэн. | Засварыг дуусгаж ашиглалтад хүлээн авсан байна. | Их засварын ажлыг "Соотон Чоно" ХХК шалгарч засварыг дуусгаж ашиглалтад хүлээн авсан. | 100% |
| 1.1.8 | Баяннуур сумын Соёлын төвийн засварын ажлын үлдэгдэл санхүүжилтийг олгох | ОНТ 15.5 сая төгрөг | Санхүүжилт хийгдсэн эсэх | 219.3 сая төгрөгийн ажил хийгдсэн. | Санхүүжилт гүйцэтгэгчийн дансанд бүрэн шилжсэн байна. | Засварын ажлын үлдэгдэл санхүүжилт 15.5 сая төгрөгийг 2024 оны Орон нутгийн төсөвт тусгуулж гүйцэтгэгч Густокек ХХК-д шилжүүлсэн. | 100% |
| 1.1.9 | Ардын Хатанбаатар Магсаржавын Дуулгат Бунханд засвар хийх зураг төсвийг хийлгэх | ОНТ | Зураг төсөв хийгдсэн эсэх | - | Зураг төсөв, хийгдсэн байна | Аймгийн Музейд чиглэл өгч 2024 оны орон нутгийн төсөвт санал хүргүүлсэн ч шийдэгдээгүй. Аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөлд тусгуулахаар аймгийн ЗДТГ-т санал хүргүүлсэн. | 0% |
| ***1.2. Соёлын салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, соёлын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах*** | | | | | | | |
| 1.2.1 | Соёлын салбарын хүний нөөцийг бэлтгэх | УТ ОНТ | Дэмжлэг үзүүлсэн хүүхдийн тоо | 5 оюутанд дэмжлэг үзүүлсэн. | Болзол, шаардлага хангасан хүүхдүүдэд дэмжлэг үзүүлсэн байна. | Соёл урлагийн их сургуулийн ур чадварын шалгалтыг аймагтаа зохион байгуулж болзол шаардлага хангасан 5 оюутанд Аймгийн Засаг даргын нэрэмжит сургалтын төлбөрийн 22 сая төгрөгийн тэтгэлгийг олгосон. | 100% |
| 1.2.2 | Соёлын салбарт ажиллаж байгаа мэргэжлийн бус ажиллагсдыг мэргэжлийн болгоход дэмжлэг үзүүлэх | УТ ОНТ | Суралцсан хүний тоо | 2023 онд 8 хүнд дэмжлэг үзүүлсэн. | 2-оос доошгүй хүнийг сургасан байна. | 6 байгууллагын мэргэжлийн бус 9 албан хаагчийг Соёлын урлагийн их сургууль болон Сити их сургуульд эчнээгээр суралцуулж мэргэжил эзэмшүүлж байна. Эдгээр ажилтнуудад суралцах хугацааны цалинг бүрэн олгож дэмжлэг үзүүлж байна. | 100% |
| 1.2.3 | Олон Улсын болон Улс, бүс нутгийн хэмжээнд зохион байгуулагдах уралдаан тэмцээнд театр, мэргэжлийн уран бүтээлчид, хүүхэд залуучуудыг | ОНТ-22.5 сая төгрөг | дэмжлэг үзүүлсэн тоо. | 2023 онд 4 уран бүтээлч, 1 сурагчдын хамтлагт дэмжлэг үзүүлсэн. | 5 удаа дэмжлэг үзүүлсэн байна. | Би эстрадын дуучин улсын уралдаанд 3 сурагч, ОХУ-д зохион байгуулагдсан И.О.Дунаевскийн нэрэмжит Олон улсын уралдаанд 1 уран бүтээлчийг дэмжлэг үзүүлж оролцууллаа. Олон Улсын уралдаанд оролцсон 1 уран бүтээлч тэргүүн байр, улсын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | оролцуулахад бүх талын дэмжлэг үзүүлж өргөнөөр хамруулах | | | | | уралдаанд оролцсон 3 сурагч тус бүр эхний 3 байрт шалгарсан амжилт үзүүллээ. U фильм уран бүтээлийн нэгдлээс зохион байгуулсан бүжгийн уралдаанд ХЖТ-ын бүжиг ангийн уран бүтээлчдэд контент бэлтгэн оролцоход дэмжлэг үзүүллээ. БНСУ-ын Жэжү хотод зохион байгуулагдсан ТАМНА соёлын фестивальд Хөгжимт жүжгийн театрын 8 уран бүтээлч оролцож 19.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ. Орон нутгийн театруудын дунд Шилдэг уран бүтээл, шилдэг уран бүтээлч шалгаруулах улсын уралдаанд Хөгжимт Жүжгийн Театрын 32 албан хаагч оролцож СУАЖЗГ-аас 2.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. | |
| 1.2.4 | Соёлын салбарын хүний нөөцийг чадавхжуулах сургалт, хэлэлцүүлэг, зөвлөгөөн зохион байгуулах, сургалтад хамруулах | УТ ОНТ | Хамрагдсан хүний тоо, Зохион байгуулсан сургалтын тоо | Давхардсан тоогоор 423 ажилтан албан хаагч хамрагдсан. | Бүх ажиллагсадыг сургалтад хамруулсан байна. | Соёлын яамтай хамтран зохион байгуулсан хойд бүсийн салбарын ажилтны зөвлөгөөнд 135 албан хаагч, Соёлын өвийн сургалтад Соёлын төв, ордон, Музейн 18 албан хаагч, Статистикийн мэдээ гаргах сургалтад 21 байгууллагын 42 албан хаагч, дотоод хяналт хэрэгжүүлэх сургалтад 21 байгууллагын 22 албан хаагч, Удирдах ажилтны Улсын зөвлөгөөнд 20 удирдах албан хаагч, номын сангийн цахим системийн сургалтад Нийтийн номын сангийн 2 ажилтан, Музей, Нийтийн номын сангийн захирлуудыг Соёлын яамнаас зохион байгуулсан сургалтад тус тус хамруулсан. Мөн Соёлын салбарын нийт албан хаагчдыг Соёлын яамнаас зохион байгуулсан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн цахим сургалтад хамруулсан.*/Давхардсан тоогоор 415 хүн хамрагдсан./* | 100% |
| 1.2.5 | Аймгийн хэмжээнд Шилдэг соёлын ажилтанд олгох | ОНТ | Хэрэгжилт | Журмын төсөл боловсруулсан. | Журам батлуулж хэрэгжүүлнэ. | Соёлын ажилтан, уран бүтээлчдийн уран бүтээлийн чанарыг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, тэдний | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шагналын журмыг батлуулж, хэрэгжүүлэх | | | | | авьяас ур чадварыг үнэлэх зорилгоор “Оюу мэлмий” тэргүүн шагналын журмыг боловсруулан Аймгийн ИТХ-ын 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн тогтоолоор батлуулж 1 шилдэг ажилтанд олгосон. | |
| 1.2.6 | Байгууллагын албан хаагчдын “Угийн бичиг” хөтлөх ажлыг эрчимжүүлэх | УТ ОНТ | Хөтөлдөг албан хаагчийн тоо | Судалгаа гаргаж сургалтад хамруулсан | 3 албан хаагч хөтөлдөг болсон байна | Байгууллагын нийт албан хаагчид угийн бичиг хөтлөх зааврын талаар зөвлөгөө авч угийн бичгийн дэвтэртэй болсон. 3 албан хаагч Угийн зураглалаа хийж хөтөлж эхэлсэн. | 100% |
| ***1.3. Соёлын бүтээлч үйлдвэрлэл, Соёлын аялал жуулчлалыг хөгжүүлж нийгэм эдийн засагт үзүүлэх үр нөлөөг нэмэгдүүлнэ.*** | | | | | | | |
| 1.3.1 | **“Алсын хараа 2050” 1.2.2, Соёлын тухай хууль 30 дугаар зүйл,**<br>Соёлын үнэт зүйлсийг судлан соёлын орчин орон зай брэндийг бий болгох чиглэлээр дэмжлэг үзүүлэх | УТ-24.5 сая төгрөг<br>ОНТ-359.0 сая төгрөг | Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо | 5 үйл ажиллагаа зохион байгуулж 16 суманд контент бэлтгэсэн. | Соёлын нөөц орон зайд тулгуурласан соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авсан байна. | Соёлын нөөц орон зайд тулгуурласан соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр Монголын Үндэсний Олон нийтийн телевизтэй хамтран “Нэрмэл архи” “Ингэт толгойн хүн чулуу” сэдэвт Монгол өв соёлын цуврал нэвтрүүлгийг олон нийтэд хүргэлээ. Мөн Тэшиг сумын онцлог, соёлыг харуулсан “Эргэх дөрвөн цаг” нэвтрүүлэг бэлтгэж тус нэвтрүүлэгт 3 өвлөн уламжлагч оролцож орон нутгийн онцлог, өв, түүх соёлын дурсгалт газрын талаар мэдээллийг хүргэлээ. Алтаргана-2024 Олон Улсын XV их наадмын хүрээнд “Нутаг” дууны клипны зураг авалтыг Тэшиг суманд хийж тус сумын байгалийн үзэсгэлэнт газрууд, Буриад ахуй, өв соёл уламжлалыг дүрсжүүлэн олон нийтэд хүргэж Булган аймгийг зорин ирэх жуулчдын урсгалыг нэмэгдүүлсэн. Булган аймгийн Музей нь Орон нутгийн төсвийн 359.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар гадна фассад, тааз, шал, хана, агааржуулалтын хоолой, үзмэрийн гэрэлтүүлэг, сантехникийн ажлуудыг бүрэн шинэчилж улсын комисст хүлээлгэн өгч Ерөнхий боловсролын 3-р сургуулийн технологийн багш, өвлөн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | уламжлагч Л.Наранзаяатай хамтран ажиллах гэрээ байгуулан Булган аймгийн түүх соёлын дурсгал, 20 гаруй төрлийн хадны сүг зургийг гадна хананд зуруулж соёлын орон зайг бий болгон Соёлын үнэт зүйлсийг иргэдэд чанар хүртээмжтэй, тав тухтай орчинд хүргэх нөхцөлийг сайжруулсан. Хөгжимт жүжгийн театрын уран бүтээлчид жуулчдад зориулсан “Адуу айраг дагасан соёл” Брэнд тоглолтын хөтөлбөр боловсруулж Айраг фестивалийн үеэр жуулчдад зориулсан Гэр тоглолт зохион байгуулж 900 орчим хүнд хүргэсэн. Хөгжимт жүжгийн театр Анаг тур, Соёлын ордон “Баатарван”, “7 нуга” Анаг тур”, Рашаант сумын Соёлын төв “Хоёр загал”, “Монгол алтай” Могод сум “Хульж ресорт” Сэлэнгэ сум “Өэжүн”, Хишиг-Өндөр сум “Цагаан хашаат”, Дашинчилэн сум “Хар бух” зэрэг амралт, жуулчны баазуудтай хамтран ажиллаж 2200 гаруй хүнд үндэсний өв соёлоо сурталчиллаа. | |
| 1.3.2 | **Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.4, Засгийн газрын 2022 оны 314 - р тогтоол.**<br>Аймаг, бүс нутгийн онцлогт тулгуурласан соёлын бүтээлч үйлдвэрлэлийн зураглал, төлөвлөгөө боловсруулах | - | Баримт бичиг боловсруулагдсан байна. | - | Баримт бичгийн хувийг Соёлын яаманд хүргүүлсэн байна. | “Соёлын бүтээлч үйлдвэрлэл" арга хэмжээний хүрээнд орон нутгийн онцлогт тулгуурлан 2 зорилт 10 арга хэмжээ бүхий төлөвлөгөө боловсруулан батлуулж хэрэгжилтийг ханган ажиллалаа. Тус ажлын хүрээнд аймгийн соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийн нэгдсэн судалгааг шинэчлэн, хамтын ажиллагааг сайжруулах уулзалт, бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийн, үзэсгэлэн, бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийг алдаршуулах контент, өдөрлөг, тайлбарт тоглолт зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж тайланг хүргүүллээ. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.3.3 | **Соёлын тухай хуулийн 30.4, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 1.1.2, Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр 1.4.5.1** Диваажингийн сүм, Цагаан суварга, Бурхан багшийн энергийн цэцэрлэгт хүрээлэн, Ардын Хатанбаатар С.Магсаржавын бунхант цогцолбор, Баруун Замын байлдааны штаб музей зэрэг дурсгалт газрыг сурталчлах | - | Зохион байгуулсан аяллын тоо, хамрагдсан хүүхдийн тоо | 2 удаагийн явган аялал өртөөчилсөн тэмцээн уралдаан зохион байгуулж 120 хүүхэд хамрагдсан. | Булган сумын ЕБС-ийн 11-р ангийн сурагчдад 2 удаагийн аялал зохион байгуулсан байна. | Орон нутгийн түүх соёлын дурсгалт газар болон алдартнуудыг танилцуулах, өв соёлоо хайрлан хамгаалах, хүүхэд багачуудад музейн ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор "Түүх соёлоо судалья" Булган сумын түүх соёлын дурсгалт газраар" "Түүхийн жимээр" сэдэвт өртөөчилсөн явган аяллыг 3 удаа зохион байгуулж Булган сумын 1, 2, 3-р сургууль, Спортын дунд сургуулийн 5, 8, 11-р ангийн 340 сурагчийг хамруулж түүх соёлын мэдлэг ойлголтыг нэмэгдүүллээ. | 100% |
| 1.3.4 | **Соёлын тухай хуулийн 30.4, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 1.1.2, Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр 1.4.5.2** Цогт хунтайжийн цагаан балгас, Хар бухын балгас дурсгалт газруудыг хамгаалах, түүх соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх | ОНТ-1.0 сая төгрөг | Дурсгалыг хамгаалж сурталчилсан байх | Цогтын цагаан байшинд 12.0 сая төгрөгийн санхүүжилтээр шилэн хорго бүхий үзүүлэн бий болгож Монголын баялаг 330 төслийн хүрээнд тус дурсгалт газруудад контент хийгдсэн.“Цогтын цагаан байшин”, “Хар бухын балгас” түүх дурсгалын газруудыг гадаад, дотоодын 453 | Дурсгалыг хамгаалж сурталчилсан байна. | Дашинчилэн сумын Соёлын төв Хар бухын балгас дурсгалт газрын ойр орчмын самбарыг шинэчилж, орчны тохижилт хийж 2024 оны жилийн эцсийн байдлаар 380 орчим жуулчдад дурсгалт газрыг танилцуулсан. Дашинчилэн сумын Соёлын төвийн санаачилгаар Монголын эмэгтэй архитектурын холбооны санхүүжилтээр архитектур судлаач Ш.Энхтунгалаг, ҮТИС-ийн архитектурын 4 курсийн оюутнуудтай хамтран хар бухын балгасын макет бүтээж Хар бухын музейд байршуулсан. "Цогтын цагаан байшин" төслийн хүрээнд 2024 оны 3 сараас эхлэн Соёлын өвийн үндэсний төвөөс "Цогтын цагаан байшин, түүнийг сэргээн засварлах судалгаа шинжилгээг хийсэн. 2024 оны 7-р сарын 18-25-ны өдрүүдэд Судалгаанд тулгуурласан дижитал сэргээн босгох ажил хийх зорилгоор Соёлын өвийн үндэсний төв, БНСУ-ын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | жуулчин ирж,үзэж сонирхсон. | | Соёлын өвийн судалгааны үндэсний хүрээлэнгийн Эрсдэл, гамшгаас урьдчилан сэргийлэх хэлтэстэй хамтран “Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал болох сүм хийд, уран барилга, архитектурын дурсгалыг 3D цахим хэлбэрээр баримтжуулах, техникийн зураг боловсруулах, мэргэжилтэн бэлтгэх” төслийн хүрээнд Хар бухын балгас, Цогтын цагаан байшинд 3D баримтжуулалт хийж цахимд байршуулан 3200 хүнд хүргэсэн. 2024 онд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан Олон Улсын эрдэмтдийн бага хуралд "Цогтын цагаан байшин Монголын XVII зууны хотхон мөн болох нь" сэдвээр Цогт тайжийн орд өргөө сангийн тэргүүн Д.Цэрэннадмид илтгэл хэлэлцүүллээ. Аймгийн музей “Чингисийн чулууны бичиг”-ийн 800 жил, “Цогтын хадны чулууны бичээс”-ний 400 жилийн ойг сурталчилсан 2 төрлийн соёлын боловсролын хөтөлбөр зохион байгуулж 300 гаруй хүүхэд хамрагдлаа. Дашинчилэн, Баяннуур сумын Соёлын төвүүд “Цогтын цагаан байшингийн гэрэлт хөшөө” дурсгалыг танилцуулах түүхэн аяллыг ЕБС-ийн сурагчдын дунд зохион байгуулж 174 хүүхэд хамруулж танин мэдэхүйн тэмцээн зохион байгуулж контент бэлтгэн цахимд сурталчиллаа. | |
| 1.3.5 | **Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.4,** | УТ<br>ОНТ-<br>5.0 сая төгрөг | Иргэн, аж ахуй нэгжийн тоо | 16 бүтээлч үйлдвэрлэл үйлдвэрлэл эрхлэгчид дэмжлэг үзүүлсэн. | 5-аас доошгүй иргэн, аж ахуй нэгжийг дэмжсэн байна. | “Go Mongolia” арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдсан Айраг фестиваль, Нүүдэлчин дэлхийн соёлын фестиваль, Алтаргана-2024 Олон Улсын XV их наадам, Монгол гэрийн уламжлалт урлал, холбогдох зан үйл өвийг таниулах зорилгоор Улаанбаатар хотод зохион байгуулагдсан “Монгол гэр” | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Хувийн хөрөнгө оруулалтаар соёлын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй иргэн, хуулийн этгээдийн санал санаачилга, бүтээлч үйл ажиллагааг дэмжих, урамшуулах | | | | | үзэсгэлэн, Орхон аймагт зохион байгуулагдсан “Уран гар” үзэсгэлэн, Булган аймагт зохион байгуулагдсан “Орон нутагт иновацийг нутагшуулах нь” “Булганы алтан намар” зэрэг нийт 7 үзэсгэлэн, арга хэмжээнд Булган, Сайхан, Орхон, Тэшиг, Хутаг-Өндөр, Бугат, Хишиг-Өндөр, Рашаант, Сэлэнгэ сумын 26 өвлөн уламжлагчийн металь урлал, модон эдлэл, зөөлөн эдлэл, уран дархан, эсгий урлал, арьс ширэн урлалын бүтээлүүдийг олон нийтэд сурталчлан таниулах, бүтээгдэхүүнээ худалдан борлуулахад дэмжлэг үзүүлсэн. Дээрх арга хэмжээнүүдийн хүрээнд өвлөн уламжлагчид 75.5 сая төгрөгийн орлого олсон байна. 10 сумын Соёлын төв Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийн 15 удаагийн үзэсгэлэнг зохион байгуулж 56 соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгч оролцож 7 сумын Соёлын төв 14 Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчидтэй хамтран сургалт зохион байгуулж 460 хүн хамруулллаа. | |
| 1.3.6 | **Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 1.1.2, Монгол Улсын Засгийн газрын 264 дүгээр тогтоол, Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр 1.4.1.1**<br>Айраг фестиваль зохион байгуулах | ОНТ-59.6 сая | Зохион байгуулсан үйл ажиллагааны тайлан | Жил бүр зохион байгуулдаг: | Айраг фестивалийн соёл урлагийн арга хэмжээг зохион байгуулна. | “Айраг фестиваль-2024” арга хэмжээний нээлт, хаалтын үйл ажиллагаа, төв тайзны үйл ажиллагаа, Гэр тоглолт, Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийн Гэр үзэсгэлэн, “Айрагдья” соёлын арга хэмжээг зохион байгууллаа. Монгол гэр үзэсгэлэнд Булган, Орхон сумаас 6 соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч нийт 28 төрлийн бүтээлээр оролцож 516 хүнд хүрч үйлчлэн 5.5 сая төгрөгийн орлого олсон. Гэр тоглолтод Хөгжимт жүжгийн театрын 17 уран бүтээлч, Нээлтийн үйл ажиллагаа, “Айрагдья” соёлын арга хэмжээнд Хөгжимт жүжгийн театраас-20, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Улаанбаатар хотоос-11 уран бүтээлч тус тус оролцож гадаад дотоодын жуулчдад ардын язгуур урлаг, өв соёлоо сурталчлан таниуллаа. | |
| ***1.4. Соёлын өвийг хадгалах, хамгаалах, өвлүүлэн уламжлуулах арга хэмжээг нэмэгдүүлнэ.*** | | | | | | | |
| 1.4.1 | **Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 37.4, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.3.6, Байгууллагын стратеги төлөвлөгөөний зорилт 5** Иргэд, сүм хийдэд хадгалагдаж байгаа баримтат өвийг бүртгэлд хамруулах | - | Бүртгэлд хамруулсан баримтат, өвийн тоо | Иргэд сүм хийдэд хадгалагдаж буй 50 баримтат өвийг бүртгэлд хамруулсан. | 50-с доошгүй баримтат өвийг бүртгэлд хамруулна. | 5 сумын нутаг дэвсгэрт орших 6 сүм хийдэд хадгалагдаж буй 29 ширхэг бурхан шашны эд өлгийн зүйл баримтат өв, 5 сумын 8 иргэнд хадгалагдаж буй 21 ширхэг баримтат өвийг тус тус бүртгэлд хамруулсан. | 100% |
| 1.4.2 | **Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 37.4, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.3.6, Байгууллагын стратеги төлөвлөгөөний зорилт 5** Улс, аймгийн хамгаалалтад байгаа түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг иргэн, | ОНТ | Гэрээ байгуулсан иргэн, хуулийн этгээдийн тоо | 38 дурсгалыг хамгаалуулах гэрээ байгуулсан. | Харьяалах нутаг дэвсгэрт орших улсын болон аймгийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг гэрээгээр хамгаалуулах, гэрээний хуулбар Соёлын яаманд хүргүүлэх | Улс, аймгийн хамгаалалттай 53 дурсгалаас улсын хамгаалалттай 12 дурсгал, аймгийн хамгаалалттай 41 нийт 53 дурсгалыг хамгаалуулах гурвалсан гэрээг байгуулж гэрээний хувийг холбогдох байгуулагуудад хүргүүлсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хуулийн этгээдтэй гэрээ байгуулж хариуцуулна. | | | | | | |
| 1.4.3 | “**Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 1.1.7, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 1.1.4, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.3.6**<br><br>Уламжлалт аргаар хөтөлсөн угийн бичиг болон баримтат өвийг сурвалжлан олж бүртгэх, сурталчлах ажлыг зохион байгуулах | ОНТ-1.3 сая төгрөг | Бүртгэж сурталчилсан баримтат өвийн тоо | 5 угийн бичгийг сурвалжлан олж бүртгэсэн. | 2-с доошгүй угийн бичгийг сурвалжлан олж сурталчилсан байна. | Гурванбулаг, Орхон, Рашаант, Хишиг-Өндөр, Булган сумын 7 иргэнд хадгалагдаж буй Уламжлалт аргаар хөтөлсөн угийн бичгийг сурвалжлан олж анхан шатны бүртгэлийг хийж баримтжуулсан. Уламжлалт аргаар угийн бичиг хөтлөх сургалтыг Булган, Гурванбулаг, Бүрэгхангай, Могод, Рашаант, Тэшиг, Хангал сумын Соёлын төв, Аймгийн Нийтийн номын сангаас Насан туршийн боловсролын төв, ахмад багш нартай хамтран нийт 32 удаа зохион байгуулж 862 иргэд хүүхэд залуусыг хамруулсан. Уламжлалт угийн бичгийг түгээн дэлгэрүүлж сурталчлах зорилгоор Булган сумын Соёлын ордноос ЕБС-ийн 10-р ангийн сурагчдын дунд “Дэвжээ” тэмцээн, Хутаг-Өндөр сумын Соёлын төвөөс угийн бичиг хөтөлдөг иргэдийн үзэсгэлэнг тус тус зохион байгуулсан. | 100% |
| 1.4.4 | “**Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 1.2.5, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 39.3**, **Байгууллагын стратеги төлөвлөгөөний зорилт 5**<br><br>Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг сурталчлан алдаршуулах, урамшуулах | ОНТ-6.4 сая төгрөг | Урамшуулж алдаршуулсан өвлөн уламжлагчийн тоо | 2023 оны тайлан | Өвлөн уламжлагчийг тодруулж урамшуулах, алдаршуулах арга хэмжээг зохион байгуулсан байна. | Олон Улс, Улс, бүсийн чанартай 7 үзэсгэлэн, арга хэмжээнд Булган, Сайхан, Орхон, Тэшиг, Хутаг-Өндөр, Бугат, Хишиг-Өндөр, Рашаант, Сэлэнгэ сумын 26 өвлөн уламжлагчийг дэмжлэг үзүүлэн оролцуулсан.<br><br>Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг сурталчлах үзэсгэлэн, сургалт, өдөрлөг, урлагийн наадам тайлбарт тоглолтыг Булган, Баян-Агт, Бүрэгхангай, Хангал, Гурванбулаг, Дашинчилэн, Орхон, Сэлэнгэ, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр сумын Соёлын төвүүд зохион байгуулж нийт 44 өвлөн уламжлагчийг сурталчилсан. Тэшиг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сумын соёлын төв 3 өвлөн уламжлагчийг МҮОНТ-ийн Эргэх 4 цаг нэвтрүүлэгт, Бугат сумын соёлын төв 2 өвлөн уламжлагчийг баримтат киноны зураг авалтад, Баян-Агт сумын Соёлын төв 1 өвлөн уламжлагчийг Монгол өв соёл нэвтрүүлэгт оролцуулан Баян-Агт, Сэлэнгэ, Булган, Тэшиг, Бугат, Хангал сумын Соёлын төвүүд өвлөн уламжлагчийг сурталчилсан 9 контент бүтээж цахимаар түгээсэн. /Цахим хандалт 55772/<br><br>Бугат сумын Соёлын төв 1 өвлөн уламжлагчийг 900 мянган төгрөгөөр, Рашаант сумын соёлын төв 2 өвлөн уламжлагчийг сумын Засаг даргын нэрэмжит шагналаар урамшуулсан. Аймгийн Шилдэг өвлөн уламжлагч тодруулах журмын дагуу Гурванбулаг, Баяннуур, Булган, Сэлэнгэ сумаас ирүүлсэн 7 өвлөн уламжлагчийн материалтай ажлын хэсэг нэг бүрчлэн танилцаж нэг өвлөн уламжлагчийг шалгаруулж аймгийн Засаг даргад уламжилсан. | |
| 1.4.5 | **Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 1.2, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 264 дүгээр тогтоол** “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивальд оролцох | УТ-20 сая төгрөг ОНТ-13 сая төгрөг | Наадамд оролцсон тайлан | 2022 онд 41, 2023 онд 42 хүний бүрэлдэхүүнтэй оролцсон. | Фестивальд оролцож өв соёлоо сурталчилсан байна. | Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн жагсаалт болон ЮНЕСКО-ийн яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгэгдсэн Монголчууд бидний оршихуй болсон үнэт соёлын биет бус өвүүдээ өвлөн уламжлуулах, сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор 2024 оны 08 дугаар сарын 16-18-ны өдрүүдэд Улаанбаатар хотын Налайх дүүргийн Тайж хайрхны бэлд зохион байгуулагдсан “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивальд Булган аймгийн төлөөлөл 4 дэх удаагаа 45 хүний | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүрэлдэхүүнтэй оролцож 7 ай савын 362 өвийн төрлөөс эх хэл аман уламжлал, ардын язгуур урлаг, уламжлалт арга ухаан, уламжлалт гар урлал, уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай уриа дуудлага зэрэг 5 ай савд багтах 26 өвийн төрлийг түгээн дэлгэрүүлж үзүүлбэр, тоглолт, үзэсгэлэн, боловсролын хөтөлбөрөөр дамжуулан олон нийтэд таниулан сурталчиллаа. | |
| 1.4.6 | **Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого 1.1.11, Соёлын өвийг хамгаалах тухай 16.1.5, 26.1, Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолоор баталсан "Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх журам"** Түүх, соёлын хөдлөх дурсгалын тооллогыг зохион байгуулах | - | Тооллогод хамрагдсан дурсгалын тоо, тайлан | - | Булган аймгийн 15 сумын 16 Орон нутаг судлах музейд тооллого хийж тайланг хүргүүлсэн байна. | Түүх, соёлын хөдлөх дурсгалын тооллогыг зохион байгуулах бэлтгэл хангасан. Дээрх ажлын хүрээнд Музейн үзмэр, эд өлгийн зүйлийг ерөнхий бүртгэлийн дэвтэрт бүртгэж Register программд бүрэн оруулж дуусгах, сан хөмрөгөөс хасах шийдвэр гаргасан дурсгалын мэдээллийг бэлтгэх, давхардсан бүртгэлийн алдааг залруулах саналыг нотлох баримт бичиг бэлтгэх ажлыг зохион байгууллаа. /Улсын хэмжээнд нэгдсэн тооллогын ажил хойшлогдсон болно. / | 100% |
| 1.4.7 | **“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 1.1.4, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 1.1.4, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга** | - | Дэмжлэг үзүүлсэн тоо | Дэмжлэг үзүүлсэн. | 1-ээс доошгүй удаа дэмжлэг үзүүлсэн байна. | Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчийн үндэсний жагсаалтад бүртгэгдсэн 1 өвлөн уламжлагчийг Улаанбаатар хотод эрүүл мэндийн үзлэгт хамруулсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **хэмжээний төлөвлөгөөний 2.6.3.6.** Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн үндэсний жагсаалтад бүртгэгдсэн өвлөн уламжлагчийг эрүүл мэндийн үзлэгт хамруулахад дэмжлэг үзүүлэх | | | | | | |
| 1.4.8 | **Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 1.2.1, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 141.1.10.** ЮНЕСКО-ийн Төлөөллийн болон Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгүүлсэн өвийн оршин тогтнох чадавхыг бэхжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. | УТ-27.5 сая төгрөг ОНТ-1.0 сая төгрөг | Зохион байгуулсан арга хэмжээний тайлан, өвийн тоо | ЮНЕСКО-д Монгол Улсаас бүртгэгдсэн 15 өв | ЮНЕСКО-ийн Төлөөллийн болон Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгүүлсэн 7-с доошгүй өвийн оршин тогтнох чадавхыг бэхжүүлэх арга хэмжээг орон нутагт хэрэгжүүлсэн байна | “Булган хангай” хойд бүсийн хүүхдийн урлагийн их наадмыг орон нутагтаа зохион байгуулж тус наадамд бий биелгээ, морин хуур, уртын дууны төрлийг оруулж нийт 3 аймгийн 21 сумаас 1000 гаруй хүүхэд оролцож өв соёлоосоо суралцаж түгээн дэлгэрүүллээ. Гурванбулаг сумын Соёлын төвөөс Манлайн баясгалан ардын язгуур урлагийн наадмыг насанд хүрэгчид, хүүхдүүдийн дунд зохион байгуулж морин хуур, уртын дуу, бий биелгээний өвийн оршин тогтнох чадавхыг бэхжүүлж 116 хүн хамруулсан. Морин хуур хөгжмийг эрхэмлэн дээдэлж, түгээн дэлгэрүүлэх, өвлүүлэн уламжлуулах, оршин тогтнох чадавхыг бэхжүүлэх зорилгоор “Эгшиглэнт хөг” өсвөрийн морин хуурчдын уралдааныг аймгийн хэмжээнд нээлттэй зохион байгуулж 40 орчим өсвөрийн морин хуурчид оролцлоо.<br><br>Аймгийн хэмжээнд Театр, Соёлын төвүүдийн дэргэдэх дугуйлангуудад бий биелгээ-449, морин хуур-245, шагайн харваа-123, уран бичлэг-15, хөөмий-8, уртын дуу-56, лимбэ-211, нийт 1107 хүүхэд, хичээллүүлж өвийн оршин тогтнох чадавхыг бэхжүүлж байна. Улаанбаатар хотод зохион | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулагдсан Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл, холбогдох өвийг таниулах үзэсгэлэнд монгол гэр урлах, барих, буулгах, монгол гэрийн уяа зангилаа, холбогдох зан үйлийг таниулах 4 төрлийн боловсролын хөтөлбөр хэрэгжүүлж нийт 10977 иргэд, хүүхэд залууст сурталчлан таниуллаа. “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивальд Хөхүүрийн айраг исгэх уламжлал, холбогдох зан үйл, морин хуур, лимбэ, шагайн харваа, уран бичлэг, уртын дууны өв соёлыг сурталчлан 6000 орчим хүнд хүргэлээ.<br><br>Айраг фестивалийн хүрээнд Хөхүүрийн айраг исгэх уламжлал, холбогдох зан үйл өвийг сурталчилсан 5 төрлийн тэмцээн уралдаан зохион байгуулж айраг, адуу дагасан соёлыг сурталчилж 400 гаруй жилийн түүхтэй Хангинахын шугуйн шагайн тойром эвент арга хэмжээг 9 дэх жилдээ зохион байгуулж шагайн харвааны өвийг сурталчиллаа. | |
| 1.4.9 | **ЮНЕСКО-ийн Соёлын биет бус өвийг хамгаалах тухай конвенцын 29 дүгээр зүйл**<br>ЮНЕСКО-ийн Соёлын биет бус өвийг хамгаалах тухай 2003 оны конвенцын хэрэгжилтийн тайланг боловсруулахад дэмжлэг үзүүлнэ | - | тайланд тоон дүн мэдээг бэлтгэж хүргүүлэх | ЮНЕСКО-ийн Соёлын биет бус өвийг хамгаалах тухай конвенцын 29 дүгээр зүйл | 2017-2023 оны хооронд соёлын биет бус өвийг хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл, төсөв, хамрагдсан өвлөн уламжлагч, иргэдийн тоо, үр дүн бүхий мэдээллийг боловсруулж, тайлан бэлтгэх ажлын хэсэгт хүргүүлэх | ЮНЕСКО-ийн Соёлын биет бус өвийг хамгаалах тухай 2003 оны конвенцын хэрэгжилтийг хангах хүрээнд 2017-2023 онд Соёлын биет бус өвийн чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайланг нэгтгэн ЗГХА-Соёл урлагийн газарт хүргүүлсэн. | 100% |
| 1.4.10 | **Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 1.1.2, Соёлын** | ОНТ-6.0 сая төгрөг | Хамтран хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн тоо | 2 төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн. | 2-оос доошгүй хамтарсан төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна. | “Алтаргана-2024” Олон Улсын XV их наадмын хүрээнд Баруун Буриадын суухан хуур хөгжим болох соёлын биет бус өвийг хадгалж хамгаалах, орон нутгийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **яамны стртаеги төлөвлөгөөний 3 дугаар зорилт** Төр, хувийн хэвшил, орон нутгийн байгууллага болон иргэний нийгмийн байгууллагын түншлэл, хамтын ажиллагааг бэхжүүлж, соёлын өвийг хамгаалах чиглэлийн хамтарсан төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | | | | | угсаатны онцлогийг илэрхийлсэн брэнд хөгжмийг олон нийтэд сурталчлах зорилгоор “Суухан хуур” төслийг хэрэгжүүлэн Тэшиг сумын Соёлын төвд 30 ширхэг суухан хуур хөгжмийг шийдвэрлүүлж 10 хүүхэд, 10 насанд хүрэгчдэд суухан хуурын сургалт зохион байгуулж төр, хувийн хэвшил, орон нутгийн байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлэн ажиллалаа. “Үндэсний бичиг, соёлын жил-2024, Чингисийн чулууны бичиг-800 жил, Цогтын хадны бичээс-400 жилийн хүрээнд аймгийн нутаг дэвсгэрт орших бичиг үсгийн дурсгалд холбогдох өвийг дүрсжүүлэх, хадгалж хамгаалах, олон нийтэд сурталчлах зорилгоор “Бичиг үсгийн дурсгалд холбогдох өв” төслийг боловсруулан Юнескогийн Соёлын олон төрлийг дэмжих Олон Улсын санд хүргүүллээ. Соёлын өвийг хамгаалах, эрдэм шинжилгээ судалгааны эргэлтэд оруулах зорилгоор Монгол Улсын Их сургуулийн Археологийн судалгааны төв АНУ-ын Археологийн судалгааны байгууллагатай хамтран Тэшиг сумын Залам хайрхан, Тарвагатайн голд археологийн судалгаа, ШУА-ны Түүх угсаатны зүйн хүрээлэн, ОХУ-ын Археологийн хүрээлэнтэй хамтран Бийбулаг-2024 археологийн судалгаа, Соёлын өвийн үндэсний төв ШУА-ны Археологийн хүрээлэнтэй хамтран Ингэт толгойн археологийн судалгааны төслийг хэрэгжүүлж Судалгаанд тулгуурласан дижитал сэргээн босгох ажил хийх зорилгоор Соёлын өвийн үндэсний төв, БНСУ-ын Соёлын өвийн судалгааны үндэсний хүрээлэнгийн Эрсдэл, гамшгаас урьдчилан сэргийлэх | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэлтэстэй хамтран “Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал болох сүм хийд, уран барилга, архитектурын дурсгалыг 3D цахим хэлбэрээр баримтжуулах, техникийн зураг боловсруулах, мэргэжилтэн бэлтгэх” төслийн хүрээнд Хар бухын балгас, Цогтын цагаан байшинд 3D хэмжилт судлагаа хийж ажилласан. | |
| 1.4.1 1 | Аймгийн нутаг дэвсгэрт орших Соёлын биет өвийн Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг бүртгэлжүүлэх | - | Шинээр бүртгэсэн дурсгалын тоо | 3 соёлын биет өвийн дурсгалыг бүртгэлд хамруулсан. | Шинээр 8-с доошгүй дурсгалыг бүртгэлд хамруулна. | Бүрэгхангай сумын Дархан багийн нутагт орших Бүрээ толгойн Хийдийн туурь, Цахт багийн нутагт орших Улаан тугалын хүрээний хийдийн туурь, Баян-Агт сумын Дулаанхан багийн нутагт орших Хадны бичээс-1, Баяннуур сумын Хан-Шахайт багийн нутагт орших Хөшөө чулуу-1, Хадны сүг зураг-1, Булган сумын 5-р багт байрлах Цогт Хун тайжийн хөшөө-1, Төгсөгчдийн сааданд байрлах Хэлмэгдэгсдийн хөшөө, 1-р багт байрлах Хийморийн овоо нийт 8 Түүх соёлын үл хөдлөх дурсгалын анхан шатны бүртгэлийг хийж шинээр Rich.mongoluv.mn программд бүртгэх саналыг холбогдох байгууллагад хүргүүлсэн. | 100% |

***1.5. Бүх нийтийн соёлын боловсрол олгох хөтөлбөрийн хүрээнд орон нутагтаа холбогдох арга хэмжээг зохион байгуулж, ард иргэдийг соён гэгээрүүлэх ажлыг идэвхжүүлж, үндэсний соёлын дархлааг нэмэгдүүлнэ.***

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.5.1 | **Соёлын тухай хуулийн 4.1.2, 14.2.1, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 1.3.2, Монгол хэлний тухай хуулийн 7.2, 14.1.1, 17 дугаар зүйл, "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III" 3.2.15,** “Үндэсний бичиг, соёлын жил-2024, Чингисийн чулууны бичиг-800 жил, Цогтын хадны бичээс-400 жил, "Эх хэлний өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх, Үндэсний бичиг соёлыг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах | УТ 2.8 сая төгрөг | Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо | Үндэсний бичиг үсгийн баяр, Эх хэлний өдөр, Хос бичигтэн байгууллага арга хэмжээг хэрэгжүүлсэн. | Жилд 8-аас доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна. | Үндэсний бичиг соёл номын өдрүүд арга хэмжээ, Соёлын бүтээлч сар аяны хүрээнд Аймгийн Нийтийн номын сан болон Соёлын төвүүд бичиг соёлыг сурталчлах Бид монгол бичигтэн, Сайхан бичигтэн, Хурдан уншигч”, Уран бичлэг, Монгол бичгийн гайхамшиг , “Төр, нийгмийн зүтгэлтэн С.Удвал” бяцхан ном бүтээх, “Буриад өв соёл” ханын сонин бүтээх уралдаанууд, уран бичлэг, үндэсний бичгээр хэвлэгдсэн номын үзэсгэлэн, бийрэн бичиг, үнсэн самбар, өдөөр, бэхээр бичих үзүүлбэр, соёлын боловсролын хөтөлбөр зэрэг 10 нэр төрлийн үйл ажиллагааг зохион байгуулж 5553 хүүхэд, залуусыг хамрууллаа. Үндэсний бичгийн 18 цагийн цахим хичээлийн линкийг харьяа байгууллагуудад хүргэж Аймгийн Нийтийн номын сан, Соёлын төвийн 20 номын санч цахим хичээлд хамрагдсан. Байгууллагын вэб сайтын цэсүүдийг үндэсний бичгээр үйлдэж 22 төрлийн онцлох мэдээллийг үндэсний бичгээр бичиж байршуулан үндэсний бичгийн цахим хэрэглээг нэмэгдүүлж, хэрэглээний орчин бүрдүүлсэн. Аймгийн Музей “Чингисийн чулууны бичиг”-ийн 800 жил, “Цогтын хадны чулууны бичээс”-ний 400 жилийн ойг сурталчилсан 2 төрлийн соёлын боловсролын хөтөлбөр зохион байгуулж 300 гаруй хүүхэд хамрагдлаа. Дашинчилэн, Баяннуур сумын Соёлын төвүүд “Цогтын цагаан байшингийн гэрэл хөшөө” дурсгалыг танилцуулах түүхэн аяллыг зохион байгуулж ЕБС-ийн 174 сурагчийг хамруулж танин мэдэхүйн тэмцээн зохион байгуулсан. Монголчуудын хэрэглэж ирсэн бичиг, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үсэг болон бичиг үсгийн дурсгалуудын талаарх 8 контентийг цахим хуудсаар болон Соёлын орон зай нэгдсэн өдөрлөг, Үндэсний бичиг соёл номын өдрүүд нэгдсэн арга хэмжээний хүрээнд лед дэлгэцээр сурталчлан 600 гаруй хүнд хүргэсэн. Аймгийн нутаг дэвсгэрт орших бичиг үсгийн дурсгалд холбогдох өвийг дүрсжүүлэх, хадгалж хамгаалах, олон нийтэд сурталчлах зорилгоор "Бичиг үсгийн дурсгалд холбогдох өв" төслийг боловсруулан Юнескогийн Соёлын олон төрлийг дэмжих Олон Улсын санд хүргүүллээ. СУАЖЗГ, Соёлын ордон 20 цагийн түвшин ахиулах төлбөртэй сургалтад нийт 17 албан хаагчийг хамруулсан. | |
| 1.5.2 | **Соёлын тухай хуулийн 23 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.2, Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр 1.4.1.4, Байгууллагын стратеги** | УТ ОНТ-42.9 сая төгрөг, | Зохион байгуулсан арга хэмжээний тоо, нөлөөллийн аяны тоо | 4 зорилт 22 арга хэмжээ бүхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлсэн. | Жилд 20-оос доошгүй арга хэмжээ, 2-оос доошгүй нөлөөллийн аян зохион байгуулж тухайн орон нутгийн бүх шатны байгууллага, хувийн хэвшил, ТББ, иргэдийг уриалах | Бүх нийтийн соёлын боловсрол олгох 4 зорилт 24 арга хэмжээ бүхий төлөвлөгөө боловсруулан батлуулж бүрэн хэрэгжүүллээ. Тус ажлын хүрээнд Соёлын бүтээлч сар, Соёлын сэргэлт, Хүүхдийн бүтээлч уншлага, Өглөөний уншлага, Уншигч гэр бүл , Цагдаагийн газартай хамтран Нийгмийн харилцааны соёлыг дээшлүүлэх зорилгоор Дээрэлхэл дэлгэрэх ёсгүй аяныг аймгийн хэмжээнд тус тус зохион байгуулж, Үндэсний бичиг соёл номын өдрүүд, яруу найргийн уралдаанууд, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **төлөвлөгөөний зорилт 4** Бүх нийтийн соёлын боловсрол, нийгмийн харилцааны соёлыг дээшлүүлэх олон талт арга хэмжээ, нөлөөллийн аяныг зохион байгуулах | | | | | бүсийн хүүхдийн урлагийн их наадам, тоглолт, арга хэмжээ, нүүдлийн ахуй, үндэсний өв соёлыг таниулах боловсролын хөтөлбөр, соёлын өвийг таниулах аялал, Номтой нөхөрлөх цаг подкаст, эерэг хандлага төлөвшүүлэх контент, постер, хүүхдэд зориулсан уран бүтээл, уламжлалт өв соёл, танин мэдэхүйн сургалт, нөлөөлийн ажил, боловсролын хөтөлбөр уралдаануудыг зохион байгуулж бүх нийтэд соёлын боловсрол олголоо. /6 аян, 24 төрлийн арга хэмжээ/ | |
| 1.5.3 | **Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.2** Зохиолч яруу найрагчдын уулзалт, яруу найргийн уралдаан, наадам зохион байгуулах | ОНТ-5.3 сая төгрөг | Зохион байгуулсан ажлын тайлан | Аймгийн болон бүсийн хэмжээнд 2, 11 сумын хэмжээнд 15 удаагийн арга хэмжээ зохион байгуулж 600 орчим иргэд, хүүхэд залуусыг хамруулсан. | Утга зохиолоор дамжуулан иргэдийг соён гэгээрүүлэх, яруу найрагч, зохиолч, зохиол бүтээлийг сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулна. | “Дэлхийн яруу найргийн өдрийг тохиолдуулан Аймгийн Нийтийн номын сан, Соёлын ордон хамтран “Яруу найргийн уулзалт” зохион байгуулж 25 яруу найрагч оролцсон. Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газартай хамтран “Хүрэл тулга-2024” өсвөрийн яруу найрагчдын аймгийн уралдааныг зохион байгуулж 38 хүүхэд оролцсон. 10 сумын Соёлын төв */Бугат, Бүрэгхангай, Гурванбулаг, Дашинчилэн, Орхон, Рашаант, Сэлэнгэ, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр, Соёлын ордон/* утга зохиолоор дамжуулан иргэдийг соён гэгээрүүлэх, яруу найрагч, зохиолчдын, зохиол бүтээлийг сурталчлан таниулах зорилгоор уран жиргээ, хүрэл тулга, уран үгсийн чуулган зэрэг уралдааныг орон нутагтаа зохион байгуулж 583 хүүхэд хамруулж соёлын боловсрол олголоо. Дархан-Уул аймагт зохион байгуулагдсан “Гал Өд” улсын яруу найргийн уралдаанд МЗЭ-ийн гишүүн Б.Орхончимэг, Н.Үржинбадам, яруу найрагч Б.Отгонсувд нарыг дэмжиж оролцууллаа. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.5.4 | **Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.2, Музейн тухай хуулийн 7.1.6, Байгууллагын стратеги төлөвлөгөөний зорилт 4**<br>Гэр бүлд чиглэсэн музейн боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэх | - | Боловсролын хөтөлбөрийн тоо | 2023 онд 5 боловсролын хөтөлбөр хэрэгжүүлж 258 хүн хамрагдсан. | Жилд 2-с доошгүй боловсролын хөтөлбөр хэрэгжүүлнэ. | "Улаанбаатар хотод зохион байгуулагдсан "Монгол гэр" үзэсгэлэн болон Ерөнхий боловсролын сургуулиуд, Музейн танхимаар уламжлалт ахуй, түүх соёлыг таниулах Уламжлалт уяа зангилаа", "Уран зураг" "Соёлын биет ба биет бус өв", "Хатанбаатар С.Магсаржавын дуулгат бунхан", "Булган аймгийн музейн түүх" сэдэвт 5 төрлийн боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлж 11800 хүнд хүргэсэн. Үүнээс Уламжлалт уяа зангилаа", "Уран зураг" сэдэвт гэр бүлд чиглэсэн 2 боловсролын хөтөлбөрт 10 гэр бүлийг хамруулсан. | 100% |
| 1.5.5 | **Соёлын тухай хуулийн 11.4, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 16.1, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.2**<br>Хүчирхийлэл, хорт зуршил, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн соён гэгээрлийг дэмжих сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах | УТ-9.8 сая төгрөг | Арга хэмжээний тоо | 2022 онд 2 контент 2023 онд 3 контент бэлтгэн хүргэсэн. | Жилд 2-с доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна. | Аймгийн Цагдаагийн газартай хамтран "Дээрэлхэл дэлгэрэх ёсгүй" аяны хүрээнд Булган сумын Соёлын ордны дэргэдэх Алухай хамтлаг "Чи ганцаараа биш" дууны уран бүтээл, Хөгжимт жүжгийн театрын уран бүтээлчид хүчирхийллийн эсрэг ээрэг хандлага төлөвшүүлэх контент бэлтгэж, "Гэрэл асаая" нөлөөллийн арга хэмжээг Цогт Хун тайжийн талбайд зохион байгууллаа. Мөн байгууллагын цахим хуудсаар нийгмийн соён гэгээрлийг дэмжих 3 төрлийн постер 4 цуврал контент бэлтгэн олон нийтэд хүргэлээ. */Нийт цахим хандалт-36.4 мянга/*<br><br>Гэр бүлийн харилцаа, Гэр бүлийн хүчирхийлэл, Хүүхдийн эрх үүрэг, Гэр бүлийн соёл, Гэр бүлийн үнэт зүйл, Мэндлэх хүндлэх соёл, Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Ухаан далай номоос эхтэй, Монгол хүний эрхэмлэх үнэт зүйл, Номын соёлт ертөнц, Сурагчдын аюулгүй байдал сэдэвт нийт 26 удаагийн сургалт | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нөлөөллийн ажил зохион байгуулж 1445 хүн хамрагдсан. Баяннуур сумын Соёлын төв хүүхдийг эрсдлээс урьдчилан сэргийлэх "Ногоон гэрэл-Цагаан шугам" тэмцээнийг зохион байгуулж 129 хүүхэд хамрууллаа. | |
| 1.5.6 | **Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5.1.17, Номын сангийн тухай хуулийн 23.2, 24.4, БСШУСайдын 2018 оны А/683 дугаар тушаал, МУ-ын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлиг** “Номын баяр-2024” зохион байгуулах | УТ ОНТ-5.4 сая төгрөг<br><br>Хандив-4.5 сая | Зохион байгуулсан үйл ажиллагааны тайлан, тоо | Хавар, намрын номын баярын хүрээнд 2023 онд 29 төрлийн үйл ажиллагаа зохион байгуулж 6300 орчим иргэд хүүхэд залуусыг хамруулж 671 ширхэг, 9.4 сая төгрөгийн номоор фонд баяжилт хийсэн | Номын баярыг тэмдэглэн өнгөрүүлж 20-оос доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна. | Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.17 дахь заалт, “Номын баяр тэмдэглэн өнгөрүүлэх тухай” Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлигийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Үндэсний бичиг, соёл, номын өдрүүдэд хавар, намрын арга хэмжээг нэгдсэн удирдамжийн дагуу 16 сум 1 тосгоны хэмжээнд тэмдэглэн өнгөрүүллээ. Тус арга хэмжээний хүрээнд Номын сангийн хууль сурталчлах, мэргэжил сурталчлах, театрчилсан үлгэр, номын хэлэлцүүлэг, мэтгэлцээн, соёлын боловсролын хөтөлбөрүүд, Монгол ардын оньсон болон хөлөгт тоглоом наадгай сурталчлах, шинэ ховор номын үзэсгэлэн худалдаа зэрэг 20 төрлийн 66 соён гэгээрүүлэх үйл ажиллагаа зохион байгуулж 4382 орчим иргэд хүүхэд залуусыг хамруулж 5.4 сая төгрөгийн төсөв зарцуулсан. Нийт 181 нэр төрлийн 279 ширхэг, 7.7 сая төгрөгний номоор фонд баяжилт хийсэн. Үнээс төсвөөс худалдаагаар 109 нэр төрлийн, 177 ширхэг, 4.6 сая төгрөгийн ном, бэлэг хандиваар 72 нэр төрлийн, 102 ширхэг, 3.1 сая төгрөгийн ном, 5 нэр төрлийн 19 ширхэг 364,580 төгрөгийн тогтмол хэвлэлээр фонд баяжилт хийсэн. Хангал сумын Соёлын төв 4.5 сая төгрөгийн хандиваар номын сангийн ширээ | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сандал, хэрэгсэл, шинэ номын баяжилт хийсэн. | |
| 1.5.7 | **Соёлын тухай хуулийн 9.1.4, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны бодлогын Зорилт 1.4.** Эрдэм судлал, түүх, соёл судлалын ажлыг зохион байгуулах | ОНТ | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 3 арга хэмжээ зохион байгуулсан. | Жилд 4-с доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна. | "Ардын хувьсгалтай холбогдсон газар нутаг", "Анхдагч алдартны музейн түүхэн замнал" сэдвээр эрдэм шинжилгээний ажил мөн мартагдаж буй өвийг сэргээх зорилгоор Булган аймгийн бичиг үсгийн дурсгалд холбогдох өв, Суухан хуур"-ын судалгааны ажлыг тус тус зохион байгуулсан. | 100% |
| 1.5.8 | **Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.2,** Аймгийн хэмжээнд "Хүүхдийн бүтээлч уншлага"-ын жилийн аян зохион байгуулах | УТ-2.4 сая төгрөг | Хамрагдсан хүүхдийн тоо | 148 бүлгийн 3550 хүүхдийг ангийн уншлагад хамруулсан | Хүүхдийн бүтээлч уншлага аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулж өмнөх оноос 10 хувийн ахиц гаргасан байна. | Хүүхэд өсвөр үеийнхнийг номтой нөхөрлүүлэх, номыг бүтээлчээр унших дадлыг эзэмшүүлэх, унших хүсэл сонирхолыг нэмэгдүүлэх, уншлагыг дэмжих ажлын хүрээнд Аймгийн хэмжээнд Бүтээлч уншлага жилийн аян зарлаж төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлж 16 сум 1 тосгоны ЕБС-ийн 5966 хүүхэд бүтээлч уншлагад хамрагдлаа. Аяны хүрээнд номын санч бүр 2-5 ангийг сонгон авч тухайн ангийн сурагчдыг жилийн эхэнд болон явцад нь номын уншлагын хурдны сорил, цээж бичгийн сорил, номын тэмдэглэл хөтлүүлэх, хуулан бичиг хийлгэж, номтой нөхөрлүүлэх соёл олон нийтийн ажил зохион байгууллаа. Өнгөрсөн оны мөн үеэс бүтээлч уншлагад хамрагдсан хүүхдийн тоо 2400 хүүхдээр нэмэгдсэн байна. | 100% |
| 1.5.9 | "Соёлын сэргэлт 2024" аяныг зохион байгуулах | ОНТ-4.1 сая төгрөг | Зохион байгуулсан арга хэмжээний тайлан | Соёлын сэргэлт 2023 арга хэмжээг зохион байгуулж 12530 хүүхэд, 2000 гаруй насанд хүрэгчид хамрагдсан. | "Соёлын сэргэлт 2024" аяныг зохион байгуулсан байна. | "Соёлын сэргэлт-2024" аяны хүрээнд "Соёлын бүтээлч үйлдвэрлэл-2024" хойд бүсийн форум, 3 аймгийн Мэргэжлийн урлагийн байгууллагын хамтарсан тоглолтыг зохион байгуулж 3 аймгийн соёл урлагийн байгууллагын онцлох ажлын талаар илтгэл хэлэлцүүлж бүсийн цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцлоо. Соёлын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууллагын 135 албан хаагчийн замын зардал, байрлах зардалд дэмжлэг үзүүлсэн. | |
| ***1.6. Үндэсний, болон орчин үеийн урлагийн төрлүүдийг хөгжүүлэх бодлогыг тэгш хүртээмжтэй хэрэгжүүлж, урлаг уран бүтээлийн чанарыг сайжруулна.*** | | | | | | | |
| 1.6.1 | **Соёлын тухай хуулийн 32.8, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.2**<br><br>Хүүхдэд зориулсан уран бүтээл туурвих, тоглолт зохион байгуулах | УТ ОНТ-3.5 сая төгрөг | Уран бүтээлийн тоо, үзэгчийн тоо | 2023 онд 2 уран бүтээл туурвиж 2793 хүүхдэд хүргэсэн. | Жилд 2-с доошгүй арга хэмжээ зохион байгуулна. | Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Соёлын ордны дэргэдэх дугуйлангийн сурагчид, Хөгжимт жүжгийн театрын уран бүтээлчид хамтран “Нэг дэлхий” тоглолт зохион байгуулж тоглолтод 20 хүүхэд, 5 уран бүтээлч оролцсон. Соёлын ордны дэргэдэх Алухай хамтлагийн тоглолтыг Сэлэнгэ, Орхон аймагт зохион байгуулж 1200 орчим хүүхэд багачуудад хүргэсэн. Хутаг-Өндөр сумын Соёлын төвийн дэргэдэх “Язгуур 2” хамтлагийн “Таван тансаг” тайлан тоглолтыг зохион байгуулж тоглолтын хүрээнд 5 бүжиг шинээр дэглэж 500 гаруй хүнд хүргэлээ. Соёлын ордон, Цагдаагийн газартай хамтран “Чи ганцаараа биш” хүүхдэд зориулсан дууны уран бүтээл туурвиж Соёлын ордны дэргэдэх Алухай хамтлаг олон нийтэд хүргэж 37.4 мянган хүн цахимаар үзсэн. | 100% |
| 1.6.2 | **Соёлын тухай хуулийн 21.1.3, 21.1.8 Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.3**<br><br>Орон нутгийн уугуул угсаатан, ястны соёлын | УТ-94.5 сая төгрөг<br><br>ОНТ-41.9 сая төгрөг | Уран бүтээлийн тоо, | 2023 онд 2 уран бүтээл шинээр туурвиж үзэгчдийн хүртээл болгосон. | 1-ээс доошгүй шинэ уран бүтээл туурвисан байна. | Монгол Улсын Төрийн шагналт, Соёлын гавьяат зүтгэлтэн С.Оюуны бүтээл “Мянган уулын цэцэг” жүжгийн уран бүтээл “Сонгодог үдэш“ концертын бүтээлийг тус тус тайзнаа тавьж үзэгчдийн хүртээл болголоо.<br><br>Мөн Хөгжимт жүжгийн театр Морьтой заяа дууны уран бүтээлийг шинээр туурвиж Молор-Эрдэнэ, Таван тэс, Есөн-Эрдэнэ бүжгийн уран бүтээл, Мичид гэрэлтэх цэнхэрхэн овоо, Ундааны дээд айраг, Жаргалын орон Булган нутаг, Нутаг, Хульжийн гол, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | онцлогт суурилсан үндэсний болон сонгодог жүжиг, концерт, дуулалт жүжгийн бүтээлийг шинээр туурвих | | | | | Ханжаргалант, Үлэмж хайрын учрал зэрэг нийт бүжгийн 3, дууны 7 уран бүтээлийг шинэчлэн олон нийтэд хүргэсэн. Рашаант сумын 40 жилийн ойд зориулан Хөгнийн цэнхэр хавар, Аав уул, Даанчиг амгалан нутаг 3 дууны уран бүтээлийг дүрсжүүлсэн. Бугат сумын 100 жилийн ойд зориулан Амин хайртай нутаг, Бугын дуутай хангай 2 дууны уран бүтээлийг шинэчилж тус тус олны хүртээл болголоо. | |
| 1.6.3 | **Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.2, Соёлын тухай хуулийн 21.1.7, 21.1.11**<br><br>Урлаг уран бүтээлийг цахим хэлбэрт шилжүүлж олон нийтэд хүргэх | ОНТ-5.0 сая төгрөг | Уран бүтээлийн тоо тоо | 5 тоглолт, уралдаан, 2 дууны уран бүтээлийг цахим хэлбэрт шилжүүлсэн. | Жилд 4-с доошгүй уран бүтээлийг цахим хэлбэрт шилжүүлж сурталчилсан байна. | Хөгжимт жүжгийн театрын уран бүтээлчдийн “Үл нурахын учир” өгүүллэг, Жаргалын орон Булган нутаг, Намхай аварга, Ханжаргалант, Миний нутгийн үзэсгэлэнг гайхмаараа, Үлэмж хайрын учрал, Аваа дурсана, Мянган уулын цэцэг, Миний сайхан ээж, “Хульжийн цэнхэр гол, "Хэнээс ч нуугаагүй хайр, “Морьтой заяа, Мичид гэрэлтэх цэнхэрхэн овоо зэрэг 12 дууны уран бүтээл, Молор-Эрдэнэ бүжгийн уран бүтээл, Дулаан сэтгэл хандивын тоглолт, “Булган хангай-2024” хойд бүсийн хүүхдийн урлагийн их наадмын гала тоглолт, Алтарганы үдэш шоу тоглолт, Соёлын ордны дэргэдэх Алухай хамтлагийн “Чи ганцаараа биш” дууны уран бүтээл, Алтаргана-2024 Олон улсын XV их наадмын сүлд дуу Нутаг, “Бадма Чагдар” анимэ зэрэг бүтээлийг тус тус цахим хэлбэрт шилжүүлэн 276900 хүнд хүргэлээ. | 100% |
| 1.6.4 | **Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний** | ОНТ-18.6 сая төгрөг | Үйл ажиллагааны тайлан | 2020, 2022 онд урлагийн наадмыг зохион байгуулсан | “Булган хангай” хүүхдийн урлагийн наадмыг бүсийн хэмжээнд нээлттэй зохион байгуулна. | Соёл урлагийн тогтвортой хөгжлийг хангах, хүүхэд багачуудын хүсэл сонирхлыг дэмжин гоо зүйн төлөвшил, хүмүүжил олгох, урлагаар дамжуулан хүүхэд бүрийн дотоод ертөнцийг нээх, соёл урлагийн чиглэлээр суралцах | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **төлөвлөгөөний 2.6.2.2, Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр 1.4.1.3**<br><br>“Булган хангай” хүүхдийн урлагийн наадам зохион байгуулах | | | | | боломжийг нэмэгдүүлэх, авьяас билиг, ур чадварыг хөгжүүлэх зорилгоор “Булган хангай-2024” хойд бүсийн хүүхдийн урлагийн их наадмыг 8 төрөл, 4 насны ангиллаар зохион байгуулж 3 аймгийн 21 сумын 1100 гаруй хүүхэд оролцлоо. Тус наадмын үеэр Соёл урлагийн их сургуулийн ур чадварын шалгалт, элсэлтийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж шалгаруулалтад тэнцсэн ардын болон дуурийн дуулаачийн мэргэжлээр суралцах 2 сурагчид Соёл урлагийн их сургуулийн урилга, концертмейстер хавсарсан хөтөлбөр, үндэсний язгуур урлаг хавсарсан хөтөлбөр, хөгжимдөх урлаг, бүжиглэх урлаг, дуу чимээний технологи зэрэг хөтөлбөрөөр суралцах 5 сурагчид Аймгийн Засаг даргын нэрэмжит 4 жилийн сургалтын төлбөрийн 100 хувийн тэтгэлэг олголоо. Урлагийн наадмыг бүсийн хэмжээнд зохион байгуулснаар багш нар, хүүхдүүд бие биенээсээ суралцах, туршлага солилцож илүү хөгжих боломжийг нэмэгдүүлсэн ач холбогдолтой арга хэмжээ боллоо. | |
| 1.6.5 | **Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.3, Соёлын тухай хуулийн 25.1.1, Аймгийн Засаг даргын үйл** | - | Үзэгчийн тоо | Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Буриад улсад зохион байгуулсан. | Орон нутгаа сурталчлах 1-с доошгүй тоглолт, арга хэмжээг зохион байгуулсан байна. | Хутаг-Өндөр, Сайхан, Дашинчилэн, Хангал, Бугат сумын 100 жилийн ойг тохиолдуулан тус сумдаас төрөн гарсан уран бүтээлчид, ардын авьяастнуудын хамтарсан “Нутгаа зорино” хүндэтгэлийн тоглолтыг UB Palace-д , Булган аймгийн Хөгжимт жүжгийн театр, Орхон аймгийн Уурхайчин Соёлын ордон, Дархан-Уул аймгийн Залуучууд театрын уран бүтээлчид хамтран “Орхон аймгийн Спорт цогцолборт “Шашин урлагийн цэнгүүн”, Соёлын сэргэлт-2024 аяны хүрээнд Орхон, Хөвсгөл, Булган аймгийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **ажиллагааны хөтөлбөр 1.4.1.3**<br><br>Орон нутгаа сурталчлах тоглолт, арга хэмжээг зохион байгуулах | | | | | Мэргэжлийн урлагийн байгууллагын уран бүтээлчдийн хамтарсан тоглолт, Дархан-Уул аймагт зохион байгуулагдсан 4 аймгийн театруудын нэгдсэн ” Уухайн түрлэгт эх орон мину” тоглолтыг тус тус хамтран зохион байгуулсан. Орхон аймгийн Хүүхэд залуучуудын театрын уран бүтээл “Хөх бэрс” драммын жүжигт Хөгжимт жүжгийн театрын 2 уран бүтээлч, Хөвсгөл аймгийн ХДТ-ын уран бүтээл “Медальгүй хүргэн” кинонд Хөгжимт жүжгийн театрын 1 уран бүтээлч оролцон тоглосон. Улаанбаатар хотын UB Palace-д Хөгжимт жүжгийн театрын дуучин МУСТА Б.Гантөмөрийн “Нутаг минь” тоглолт, Нүүдэлчин дэлхийн соёлын фестивальд “Шинэ гэрийн найр” отгийн тоглолт, Айраг фестивалийн үеэр ардын язгуур урлагийн “Гэр” тоглолтыг тус тус зохион байгуулсан.<br><br>/Нийт үзэгч-7167/ | |
| 1.6.6 | **Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 1.5, Соёлын тухай хуулийн 24.1.1, Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр 1.4.3.1**<br><br>Дэлхийн Алтаргана-XV наадам зохион байгуулах | УТ 70.0 сая ОНТ-267.4 сая төгрөг | Зохион байгуулан үйл ажиллагааны тайлан | Буриад дуу бүжгийн уралдаан, уран сайхны гэрэл зургийн уралдаан зохион байгуулж 480 орчим хүн оролцсон. | Дэлхийн Алтаргана-XV наадам зохион байгуулна. | “Алтаргана-2024” Олон Улсын XV их наадмын хүрээнд Тайз карказ, хөгжим техник тоног төхөөрөмж, гэрэл гэрэлтүүлэг, лед дэлгэц, сурталчилгааны контент бэлтгэх, сүлд дуу бүтээх, брэндбүүк бүтээх, бэлгэдэл амьтан бүтээх, сурталчилгааны “Бадма Чагдар 2” анимэ бүтээх, дууны хоолойн бичлэг хийх, дүрсжүүлэх ажлын даалгавруудыг боловсруулан батлуулж үнийн санал судалж ажлын хэсэгт танилцуулж холбогдох иргэн, аж ахуй нэгжтэй гэрээ байгуулан, нээлтийн үйл ажиллагаанд оролцох уран бүтээлчид, бүжгийн хүүхдүүдийн бэлэн байдлыг ханган ажилласан. Аймгийн Соёл урлагийн байгууллагууд 5 дэд ажлын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэсэг байгуулж 8 тэмцээн, уралдааны бэлтгэл ажлыг ханган зохион байгуулж ОХУ, ӨМӨЗО, Дорнод, Хэнтий, Улаанбаатар, Орхон, Хөвсгөл, Сэлэнгэ, Говьсүмбэр, Дархан-Уул аймгаас нийт 589 хүн оролцлоо./*Номын уралдаан, Үлгэрч, ерөөлч, магтаалчдын уралдаан, Буриад яруу найргийн уралдаан, Буриад ардын дуу дуулаачдын уралдаан, Дангина гоо бүсгүй шалгаруулах уралдаан, Буриад хүний нэг өдөр, Ардын гар урлалын үзэсгэлэн уралдаан, Орчин үеийн буриад дууны уралдаан/* Мөн “Алтарганы Үдэш” шоу тоглолт “Ёохор наадаан” галын наадмыг тус тус зохион байгуулан 60.000 орчим хүн үзэж сонирхлоо. Аймгийн Музейгээс Буриад угсаатан” үзэсгэлэн болон “Айрагтай музей” хөтөлбөрийг хэрэгжүүлж 1249 хүнд үйлчлэн 4.6 сая төгрөгийн орлого олсон. Алтаргана наадмын сүлд дуу бүтээх хүрээнд “Эго гэтэлгэх үйл” ХХК-тай 17.0 сая төгрөгийн гэрээ байгуулж "Нутаг" дууны клипийг, “Анир рекордс” ХХК-тай 5.0 сая төгрөгийн гэрээ байгуулан дууны шинэчилсэн хөгжмийн найруулага, хоолойн бичлэг, микс мастеринг хийлгэж хувиараа хөдөлмөр эрхлэгч О.Сугармаатай 2.5 сая төгрөгийн гэрээ байгуулан дууны клипэнд зориулж Буриад угсаатны бүлгийн иж бүрэн хувцасыг тус тус хийлгэсэн. | |
| 1.6.7 | **Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга** | | Зохион байгуулсан арга хэмжээний тоо, хамрагдсан хүний тоо | 2023 оны тайлан | Тэмдэглэлт болон баяр ёслолын өдрүүдийг тохиолдуулан тоглолт, арга | Тэмдэглэлт болон баяр ёслолын өдрүүдийг тохиолдуулан соёлын байгууллагууд 231 тоглолт, арга хэмжээг зохион байгуулж 52100 хүнд хүргэсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.2, Соёлын тухай хуулийн 25.1.1, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль**<br><br>Тэмдэглэлт болон баяр ёслолын өдрүүдийг тохиолдуулан тоглолт, арга хэмжээг зохион байгуулах | | | | хэмжээг чанартай зохион байгуулна. | Үзэгчийн тоо өмнөх оноос 3 хувиар өссөн үзүүлэлттэй байна. | |
| 1.6.8 | **Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого 1.1.4, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тхай хуулийн 41.1. Засгийн газрын 2019 оны 369 дүгээр тогтоол**<br>Үндэсний баяр наадмын соёл, урлагийн арга хэмжээний хүрээнд "Дээлтэй Монгол наадам", "Монголын сайхан орон" дүрслэх урлагийн үзэсгэлэн, "Монгол бахархал" гэрэл зургийн үзэсгэлэн арга хэмжээг зохион байгуулах | ОНТ 5.8 сая | Зохион байгуулсан арга хэмжээний тайлан | - | "Дээлтэй Монгол наадам", "Монголын сайхан орон" дүрслэх урлагийн үзэсгэлэн, "Монгол бахархал" гэрэл зургийн үзэсгэлэн арга хэмжээг зохион байгуулах | Төв халхын үндэсний хувцасыг хүүхэд, залууст сурталчлан таниулж, тэдэнд өв соёлоороо бахархах үзлийг төлөвшүүлэх, аймгийн уран үйлчдийг алдаршуулж, үндэсний соёлын өвөө гадаад, дотоодын жуулчдад сурталчлах, Монгол хувцасны өвөрмөц онцлогийг харуулж, үнэлэмжийг нэмэгдүүлэх зорилгоор "Дээлтэй Монгол наадам" хөтөлбөрт арга хэмжээг Цогт Хунтайжийн талбайд зохион байгуулж 7 байгууллагын 76 хүн оролцож иж бүрэн үндэсний хувцастай хүүхэд, шилдэг коллекци, үндэсний хувцастай шилдэг хос, хамгийн сайн зохион байгуулалттай оролцсон шилдэг хамт олон төрлөөр шалгаруулж урамшууллаа. Аймгийн Музей, Монголын урчуудын эвлэлийн Булган аймаг дахь салбартай хамтран Булган аймгийн түүхэнд холбогдох барилга байгууламж, түүхэн дурсгалт болон байгалийн үзэсгэлэнт газар, ан амьтан, нүүдэлчин ахуйг харуулсан бүтээлээс бүрдсэн уран зургийн үзэсгэлэнг дэлгэн 150 гаруй хүнд хүргэсэн. Алтаргана-2024 Олон Улсын XV их наадмын хүрээнд Буриад зоны | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | уламжлалт ахуй, өв соёлыг харуулсан “Буриад угсаатан” гэрэл зураг, эдлэл хэрэглэлийн үзэсгэлэнг дэглэж 1200 орчим хүнд хүргэсэн. | |
| ***1.7. Цахим соёл арга хэмжээний хэрэгжилтийг хангаан ажиллана*** | | | | | | | |
| 1.7.1 | **"Алсын хараа 2050" 5.3, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.1,Байгууллагын стратеги төлөвлөгөөний зорилт 2**<br><br>Цахим соёл" арга хэмжээний хүрээнд хөгжүүлсэн системүүдийг орон нутагтаа нэвтрүүлэх | - | Нэвтрүүлсэн системийн тоо | - | Системүүдийг нэвтрүүлсэн байна. | “Цахим соёл" арга хэмжээний хүрээнд хөгжүүлсэн 3 системийг орон нутагтаа нэвтрүүлэн ашиглаж байна. Бүтээгдэхүүн үйлчилгээг цахим орчинд таниулан сурталчлах, соёлын салбар хоорондын уялдаа холбоог сайжруулах, бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчид хамтран ажиллах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх хүрээнд CreativeHub цахим системийг орон нутагтаа сурталчлан нийт 10 байгууллага, 53 уран бүтээлч, 10 соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчийг бүртгэсэн. */Хөгжимт жүжгийн театр 12, Соёлын ордон 8, Нийтийн номын сан 1, Музей 1, Бугат 2, Бүрэгхангай 8, Гурванбулаг 6, Могод 2, Дашинчилэн 5, Орхон 8, Рашаант 2, Сэлэнгэ 7, Тэшиг 3, Хутаг-Өндөр 2, Хишиг-Өндөр 4/*<br><br>Соёлын Яамнаас санаачлан хэрэгжүүлсэн GLAM портал сайтыг орон нутагтаа нэвтрүүлэх зорилгоор соёлын байгууллагуудын ажилтан, албан хаагчдад сурталчлан Номын сан, Соёлын өвийн бүртгэл мэдээллийн санг 30 хувиар нэмэгдүүлсэн.“КОНА” системд Номын сан хөмрөгийн электрон каталог 16,489 төрлийн 37,256 ширхэг ном бүртгэсэн. Соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчийн улсын нэгдсэн бүртгэлийн /Ich.mongoluv.mn/ программ-д 16 сумын 163 соёлын биет бус өвлөн уламжлагчдын бүртгэл | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэдээллийг бүртгэлжүүлсэн. /Эх хэл аман уламжлал, илэрхийллүүд, Ардын язгуур урлаг, үндэсний уламжлалт зан үйл, ёслол баяр наадам, байгалийн болон сав ертөнцийн тухай мэдлэг зан үйл, уламжлалт арга ухаан, уламжлалт гар урлал/, Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын нэгдсэн бүртгэлийн /rich.mongoluv.mn/ программ-д 514 дурсгалт газрын 3004 түүх соёлын үл хөдлөх дурсгал бүртгэлжүүлсэн. | |
| 1.7.2 | **Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.4,**<br><br>Соёл урлагийн байгууллагуудын мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтэц (өндөр хурдны интернэт ) -ийн өнөөгийн нөхцөл байдлыг үнэлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх | - | Хэрэгжилт | - | Өнөөгийн нөхцөлд байдлыг үнэлж хүртээмжийг нэмэгдүүлсэн байна | Монголын цахилгаан холбоотой байгуулсан гэрээний дагуу 8 сумын Соёлын төвийн шилэн кабельд холбогдсон ажлын гүйцэтгэлийн судлагааг авч гэрээний дагуу хангах хурдны хэмжээнд үнэлгээ хийж, мэдээг Соёлын яамны Цахим бодлого, мэдээллийн технологийн хэлтэст хүргүүлсэн. | 100% |
| 1.7.3 | **Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 2.6.2.1, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль 8 дугаар зүйл** | - | Хуулийн дагуу хөтөлсөн эсэх | Хуулийн дагуу хөгжүүлсэн. | “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль”-ийн дагуу засварлаж, мэдээллийг тухай бүр шинэчилж баяжилт хийсэн байна. | Олон нийтийг соён гэгээрүүлэх, үндэсний бахархал, өв соёлыг таниулах, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд мэдээллийн технологийг нэвтрүүлэх цахим шилжилтийн ажлын хүрээнд Байгууллагын Вэб сайтыг “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль”-ийн 8 дугаар зүйлийн дагуу бүтэц зохион байгуулалтыг хөгжүүлж, үйл ажиллагааны мэдээ мэдээллийг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Байгууллагын вэб сайтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хөтлөх | | | | | тогтмол байршуулан кирилл болон үндэсний бичгээр хөтөлж байна. | |
| **Хоёр. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ** | | | | | | | |
| 2.1 | Соёлын сайд, аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг нэгтгэх, тайлагнах | - | Хэрэгжилтийн тайлан | Хугацаанд нь тайлагнадаг. | Гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь тайлагнасан байна. | Соёлын сайд, аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээнд тусгагдсан 6 зорилт 37 арга хэмжээ, 12 чиг үүргийн хэрэгжилтийг хуулийн хугацаанд тайлагнаж АЗДТГ-ын НБХ-д хүргүүлсэн. | 100% |
| 2.2 | Аймгийн Засаг дарга, Соёл урлагийн газрын даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нэгтгэх, тайлагнах | - | Хэрэгжилтийн тайлан | Хугацаанд нь тайлагнадаг. | Төлөвлөгөөний хэрэгжилтийг хугацаанд нь тайлагнасан байна | Аймгийн Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хугацаанд нь цахим системд тайлагнаж АЗДТГ-ын холбогдох хэлтсүүдэд хүргүүлсэн. | 100% |
| 2.3 | Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Сайдын албан даалгавар, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгтгэх, тайлагнах | - | Хэрэгжилтийн тайлан | Хугацаанд нь тайлагнадаг. | Албан даалгавар, Хөтөлбөрийн хэрэгжилтийг хугацаанд нь тайлагнасан байна | Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Сайдын албан даалгавар, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хугацаанд нь тайлагнасан. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд соёлын салбарт хэрэгжүүлсэн ажлын талаар 4 төрлийн видео бэлтгэсэн. | 100% |
| 2.4 | Бүх нийтийн Соёлын боловсролын төлөвлөгөөний хэрэгжилтийг нэгтгэх тайлагнах | - | Хэрэгжилтийн тайлан | Хугацаанд нь тайлагнадаг. | Төлөвлөгөөний хэрэгжилтийг хугацаанд нь тайлагнасан байна | Бүх нийтийн Соёлын боловсролын 4 зорилт 22 арга хэмжээ бүхий төлөвлөгөөний хэрэгжилтийг нэгтгэж ЗГХА-СУГ-т хүргүүлсэн. | 100% |
| 2.5 | Салбарын СУ мэдээ болон улирлын мэдээг хууль тогтоомжид заасан хугацаанд анхан шатны нэгжээс авч нэгтгэн хүргүүлэх | - | Хугацаанд нь хүргүүлсэн эсэх | 2023 оны тайлан | 2023 оны СУ мэдээ болон 2024 оны 1-4 дүгээр улирлын мэдээг нэгтгэж хугацаанд нь Соёлын яам, СУГ-т хүргүүлнэ | Соёл, урлагийн байгууллагын үйл ажиллагааны болон ажиллагсдын 2023 оны СУ, СУХС, 2024 оны 1,2,3-р улирлын мэдээг бүртгэлийн статистикийн 11, захиргааны 12 маягтаар нэгтгэж хуулийн хугацаанд нь | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Засгийн Газрын Хэрэгжүүлэгч Агентлаг Соёл Урлагийн Газарт байгууллагын 02 сарын 01/43, 04 сарын 01/142, 03 сарын 01/79, 06 сарын 01/290, 09 сарын 01/294 дугаар албан бичгүүдээр хүргүүлсэн | |
| 2.6 | Салбарын болон байгууллагын 2025 оны төсвийн төслийг нэгтгэн Соёлын яаманд хүргүүлэх | - | Хугацаанд нэгтгэн хүргүүлсэн эсэх | 2023 оны төсвийн төслийг нэгтгэн батлуулсан. | Хугацаанд нь нэгтгэн хүргүүлж батлуулсан байна. | Харьяа соёлын байгууллагуудын 2025 оны Төсвийн төсөл, 2026-2027 оны төсвийн төсөөллийг цагалбарын дагуу Соёлын яаманд нэгтгэн хүргүүлж төсвийн төлөвлөлтийн Fiscal программд шивсэн. | 100% |
| 2.7 | 4-с доошгүй сумын соёлын төвийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх | - | Хяналт-шинжилгээ хийсэн сумдын тоо | 3 сумын соёлын төв, Мэргэжлийн 3 байгууллагад хийсэн. | 4-с доошгүй соёлын төвд хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн байна. | Соёл урлагийн газрын даргаар Хяналт-шинжилгээ үнэлгээ хийх удирдамжийг 5-р сарын 20, 10-р сарын 21-нд батлуулж Сайхан, Баян-Агт, Хутаг-Өндөр, Тэшиг, Сэлэнгэ, Хялганат, Хангал сумын соёлын төвийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж дүгнэлт гарган илэрсэн алдаа дутагдлыг засах, цаашид гаргахгүй байх талаар зөвлөмж боловсруулж хүргүүлсэн. | 100% |
| **Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ** | | | | | | | |
| 3.1 | Соёлын салбарын ажилтан албан хаагчдыг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний сургалтанд хамруулах, бусад салбарын хуулийн мэдлэг олгох | УТ ОНТ | Сургалт арга хэмжээний тоо | 2023 онд хуулийн мэдлэг олгох 1 , салбарын чиглэлээр 4 сургалтанд 100 хувь хамруулсан | 3-с доошгүй сургалт зохион байгуулж 50 хувийг хамруулна. | Соёлын салбарын нийт албан хаагчдыг Соёлын яамнаас зохион байгуулсан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн цахим сургалтад хамруулсан. Давхардсан тоогоор 415 хүн хамрагдсан. Соёлын байгууллагын удирдлага албан хаагчдыг ТАЗ-өөс зохион байгуулдаг 7:4:10 цахим сургалтад 10 удаа хамруулсан. | 100% |
| 3.2 | | - | | - | Хөтөлбөр хэрэгжүүлж 80-аас дээш хувиар биелүүлсэн байна. | Байгууллагын албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 12 арга хэмжээ бүхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг 100%-тай хэрэгжүүлж байна. Төрийн захиргааны 5 албан хаагчид зэрэг дэвийг шинээр олгуулсан. Төрийн албаны ёс зүйн тухай | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Төрийн албан хаагчдын сургалт, нийгмийн баталгааг хангах үйл ажиллагаа хэрэгжүүлэх | | Төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлсэн байна. Хэрэгжилтийн хувь | | | хуулийн сургалтад 4, Ёс зүйн хорооны гишүүдийн сургалтад 2, Төрийн албан хаагчийн 7:4:10 сургалтад 4 албан хаагч 10 удаа, Удирдах ажилтны Улсын зөвлөгөөнд 2, Бүсийн зөвлөгөөнд 8 албан хаагч оролцлоо. Газрын албан хаагчид 16 удаагийн сургалтад давхардсан тоогоор 42 албан хаагч хамрагдсанаар 1 албан хаагч дунджаар 6 удаагийн сургалтад хамрагдсан байна. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан 8 хүүхдэд гарын бэлэг өгсөн. Байгууллагын 3 ажилтанд 1.3 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ. | |
| 3.3 | Иргэдээс ирсэн өргөдөл, гомдол, саналыг хуулийн хугацаанд шийдвэрлэн, хэрэгжилтийг улирал тутам тайлагнах | - | Иргэдээс ирсэн өргөдөл, гомдол, саналыг шийдвэрлэлтийн хувь | 2023 онд 11 өргөдөл ирсэн. | Нээлттэй утас, цахимаар, саналын хайрцаг ажиллуулж ирсэн өргөдөл гомдлыг хугацаанд шийдвэрлэж тайлагнаж хэвшсэн байна. | 2024 онд нийт 15 өргөдөл ирснийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж хариу хүргүүлсэн. | 100% |
| 3.4 | Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг цахимжуулж, хяналт тавих | - | Цахимаар хүлээн авсан Өргөдөл гомдлын тоо, шийдвэрлэлтийн хувь | Байгууллагын цахим хуудсаар өргөдөл гомдол хүлээж авах цэсийг бий болгосон. Цахимаар өргөдөл гомдол ирээгүй. | Ирсэн Өргөдөл гомдлыг бүрэн шийдвэрлэсэн байна. | 2024 онд цахимаар 1 өргөдөл ирснийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж хариу мэдэгдсэн. | 100% |
| 3.5 | Газрын хүний нөөцийг бүрэн бүрдүүлэх | - | Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний | 2023 оны байдлаар төрийн захиргааны 7, төрийн | Төрийн захиргааны албан хаагчийн тоог нэмэгдүүлнэ. | Соёл, гэгээрэл, урлаг уран бүтээл, соёлын өвийн асуудал хариуцсан мэргэжилтний сул орон тооны захиалгыг Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлсэн. Төрийн албаны салбар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | албан хаагчдын тоо | үйлчилгээний 2, албан хаагч ажиллаж байна. | | зөвлөлөөс зарласан тусгай шалгалтад тэнцсэн 2 иргэнийг Соёл гэгээрэл болон урлаг уран бүтээлийн асуудал хариуцсан мэргэжилтнээр томиллоо. Мөн шинээр жолооч томиллоо. Соёлын өвийн асуудал хариуцсан мэргэжилтний орон тоо сул байна. Захиалгыг Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлсэн. | |
| 3.6 | Төрийн албан хаагчдыг сургаж, мэргэшүүлэн, чадваржуулах | - | Мэргэшүүлэх сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | 90 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн. | 1 албан хаагчийг мэргэшүүлэх сургалтад хамруулна. | Удирдлагын Академийн Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 1 албан хаагч суралцаж төгссөн. | 100% |
| 3.7 | Төрийн ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт амжилттай хамрагдах | Өөрийн хөрөнгө | Улсын үзлэгийн шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан эсэх | - | Шалгуур үзүүлэлтийг бүрэн хангах | Шалгуур үзүүлэлтийг 90 хувиар хангасан. Архив бичиг хэргийн ажилтанг мэргэшүүлэх сургалтад хамруулж мэргэшүүлсэн. Хөтлөх хэргийн нэрсийн жагсаалтыг гаргаж баталсан. | 90% |
| 3.8 | Архив, албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг байгууллагын хэмжээнд зохион байгуулах, хяналт тавих, 2024 оны хөтлөх хэргийн нэрсийн жагсаалтыг гаргаж хэрэгжүүлэх | Өөрийн хөрөнгө | Зохион байгуулсан сургалт, хяналт шалгалтын тоо, баримт нягтлан шалгах комиссын хурал, тооллогын үр дүн | БНШК байгуулагдсан. | Хууль, заавар, дүрэм, стандартын хэрэгжилтийг бүрэн хангана. | Баримт нягтлан шалгах комисс байгуулагдаж, 2024 онд хөтлөх хэргийн нэрсийн жагсаалтыг гаргаж батлуулсан. Хууль, заавар, дүрмийн хэрэгжилт 90 хувьтай байна. | 90% |
| 3.9 | "Зөв дадал-Архигүй орчин" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд байгууллага дээрээ судалгаа гаргаж, сургалт зохион байгуулж, хяналт тавих | Өөрийн хөрөнгө | Хөтөлбөрийн хувь. | Зөрчил гаргаагүй. | Байгууллагын хэмжээнд архидан согтуурах, явдал гаргахгүй байх | "Зөв дадал-Архигүй орчин" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Байгууллагын дотоод журамд ажлын байранд буюу албан үүргээ гүйцэтгэж /томилолтоор/ явах үедээ архи согтуулах ундаа хэрэглэхгүй байх заалтыг тусгасан. Мөн байгууллагын албан хаагчдаас "Зөв дадал-Архигүй орчин" -н талаарх хийж хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх судалгаа авч дотоод | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сургалтыг зохион байгуулсан. Архидан согтуурахтай хамаатай зөрчил гараагүй. | |
| 3.10 | Нийтийн албан тушаалтны ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд гаргуулах, хадгалах, хяналт тавих, Нийтийн албанд нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ-ийг хянуулах | Өөрийн хөрөнгө | ХАСУМ-ийг тухай бүр хянуулсан алба хаагчийн тоо,хувь | Судалгааг Соёлын яаманд хүргүүлсэн. 6 албан тушаалтан хугацаанд нь мэдүүлсэн. | ХАСХОМ болон ХАСУМ-тэй холбоотой бүртгэл судалгаатай болж, зөрчил дутагдал гаргаагүй байх. | ХАСХОМ-г 6 албан хаагч хуулийн хугацаанд гаргаж хянуулсан. | 100% |
| 3.11 | Байгууллагын албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд бүрэн хамруулах | - | Байгууллагын албан хаагчдыг бүрэн хамруулах | Нийт 10 албан хаагчийг эрт ирүүлэгт хамруулсан. | Нийт албан хаагчийг эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамруулсан байна. | Аймгийн Нэгдсэн эмнэлэгт 11 сарын 04-ны өдөр Урьдчилан сэргийлэх үзлэгт бүх албан хаагч хамрагдсан. | 100% |
| 3.12 | “Хос бичигтэн байгууллага-2025” болох бэлтгэл ажлыг хангах | ОНТ | Албан хаагчдын мэдлэгийн түвшингийн ахиц | Суурь түвшин тодорхойлог дсон. | Байгууллагын нийт албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэгийг Дунд түвшинд хүргэнэ. | 2 ажилтан Удирдлагын Академиас зохион байгуулсан сургалтад хамрагдаж Сертификат авсан. 5 ажилтны компьютерт Монгол бичгийн фондыг суулгалаа. Насан туршийн боловсролын төвтэй хамтран ажиллагсдыг 20 цагийн сургалтад хамруулсан. Байгууллагын хэвлэмэл хуудсын эхийг Монгол бичгээр гаргаж хэвлүүлэх зөвшөөрөл авахаар байгууллагын 10 дугаар сарын 14-ны өдрийн 01/314 албан бичгээр Аймгийн Архивын тасагт хүргүүлсэн. | 100% |
| 3.13 | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, Бүх нийтээр мод бут тарих ажилд зохион байгуулалттайгаар оролцох | - | Булган сумын ЗДТГ-аас хуваарилсан тооны мод тарьж, арчлан ургуулна. | Жил бүр хуваарийн дагуу мод тарьж, арчилгааг хариуцдаг. | Ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлсэн байх | Булган сумын ЗДТГ-аас ирүүлсэн хуваарийн дагуу 10 мод тарьж арчлалтыг хариуцаж байна. Өнгөрсөн жил тарьсан Модны ургалт 90 хувьтай байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.14 | "Цэвэр орчин-Цэмцгэр Булган" аянд идэвхитэй оролцож, бүх нийтийн цэвэрлэгээнд оролцох (зам дагуу хог цэвэрлэгээний ажил, орчны 50 метрийн хог хаягдал, хог ургамал, цас мөсийг арилгах) | - | Зохион байгуулсан нийтийн цэвэрлэгээний ажилд идэвхитэй оролцоно. | - | Хотын өнгө үзэмжийг сайжруулж, тав тухтай амьдрах орчинг бүрдүүлнэ. | Булган сумын ЗДТГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу цас хайлсны дараа орчны 50 метр талбайг цэвэрлэж бүх нийтийн ажилд 2 удаа оролцсон. | 100% |
| **Дөрөв. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээ** | | | | | | | |
| 4.1 | **Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.2,** Сумдад аялан тоглолт зохион байгуулах | УТ ОНТ | Аялан тоглолтын тоо | 10 суманд аялан тоглолт зохион байгуулсан. | 4-с доошгүй суманд аялан тоглолт зохион байгуулна. | Хөгжимт жүжгийн театрын уран бүтээлчид Хутаг-Өндөр суманд “Бид Булганыхан” нэгдсэн тоглолт, Хангал суманд “Төгсөгчдийн уянга” тоглолт Тэшиг суманд “Жаргал дүүрэн аялгуу” тоглолт, Хялганат тосгоны Соёлын төвийн 50-н жилийн ойн хүндэтгэлийн тоглолт, Хутаг-Өндөр суманд тариаланч малчдад зориулан “Их Хүндэтгэл” тоглолтыг Соёлын ордны дэргэдэх Алухай хамтлаг Орхон, Сэлэнгэ аймагт тус тус аялан тоглолт зохион байгуулж 2000 орчим иргэдэд хүргэлээ. | 100% |
| 4.2 | **Музейн тухай хууль 7.2**<br>Музейн үйлчилгээний нэр төрлийг олшруулах замаар үйлчлүүлсэн иргэдийн тоог нэмэгдүүлнэ. | ОНТ | Үйлчлүүлсэн иргэдийн тоо | 2023 онд үйлчлүүлсэн иргэдийн тоо 16.3 мянга | Аймгийн нийт иргэдийн 20 хувиас багагүй иргэдэд музейн үйлчилгээ үзүүлсэн байна. | Түүх соёлын үл хөдлөх дурсгал танилцуулах явган аялал, боловсролын хөтөлбөрүүд, виртуал музей, “Айргатай музей”, түр болон нүүдлийн үзэсгэлэнгүүд, “Музей үзсэн өдрийн тэмдэглэл”, “Булган аймгийн музейн лого”-ны уралдаан, эрдэм шинжилгээний ажил зэрэг үйлчилгээний нэр төрлийг олшруулан 27299 хүнд хүрч үйлчилсэн байна. | 100% |
| 4.3 | **Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний** | УТ ОНТ | Оролцсон гэр бүлийн тоо, уншлага хийсэн тоо | - | Гэр бүлийн ном уншлагыг дэмжих хөдөлгөөн өрнүүлж “Уншигч гэр бүл” шалгаруулах | “Гэр бүлийн уншлага өдөрлөг”-т 5 гэр бүлийн 14 хүнийг урьж оролцуулан 85 номоор үзэсгэлэн гаргаж, 59 номтой гэрийн номын сан сурталчилж 4 гэр бүлийн дунд “Номын нэр таах” тэмцээн зохион байгуулж Номын баярын үйл | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **төлөвлөгөөний 2.6.2.2,** “Уншигч гэр бүл” хөдөлгөөн өрнүүлэх | | | | | ажиллагаанд оролцуулсан. Нийт 6 гэр бүлийг 11 удаа гэр бүлийн уншлагад хамруулж "Уншигч гэр бүл” шалгаруулж урамшуулсан. | |
| 4.4 | **Соёлын тухай хуулийн 25.1.4**<br>Соёлын байгууллагуудын үйл ажиллагаанд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх | УТ ОНТ | Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн байгууллагын тоо | - | 5-аас доошгүй соёлын байгууллагад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгнө. | Сайхан, Баян-Агт, Хялганат, Сэлэнгэ, Хангал сумын Соёлын төвд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн. | 100% |
| **5. Хэлтсийн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ** | | | | | | | |
| **5.1 Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ** | | | | | | | |
| 5.1.1 | Аймгийн удирдах ажилтны шуухай хуралд оролцож, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг байгууллагын дарга нарт мэдээлэх | - | Зохион байгуулсан хурлын ирцийн бүртгэл | - | Удирдах ажилтны хуралд 24 удаа оролцож. Цаг үеийн шинжтэй мэдээллийг харьяа байгууллагуудад хүргэнэ. | Удирдах ажилтны шуурхай хуралд оролцож цаг үеийн шинжтэй мэдээллийг харьяа байгууллагуудад хүргэн ажилласан. | 100% |
| 5.1.2 | Төр, иргэний нийгмийн хамтын ажиллагааг дэмжиж хамтран ажиллах | - | Зохион байгуулсан ажил, арга хэмжээний тоо | - | 5-с доошгүй ТББ, иргэнтэй хамтран ажиллана. | Монгол гэрийн уламжлалт урлал, холбогдох зан үйл өвийг таниулах “Монгол гэр” үзэсгэлэнгийн хүрээнд монгол гэр, гэрийн тавилга хийлгэх контент бүтээлгэх, Соёлын бүтээлч сарын хүрээнд Бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэх контент бүтээлгэх, Алтаргана-2024 Олон Улсын XV наадмын хүрээнд сурталчилгааны анимэ бүтээлгэх, дууны клип бүтээх, хувцас хийлгэх, сурталчилгааны хэвлэлтүүд бэлтгэх, Булган хангай хойд бүсийн хүүхдийн урлагийн их наадам, Хангинахын шугуйн шагайн тойром, Айраг фестиваль, Нүүдэлчин дэлхийн соёлын фестивалийн үйл ажиллагааны | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүрээнд нийт 7 төрийн бус байгууллага, 17 иргэнтэй хамтран ажиллалаа. | |
| 5.1.3 | Гадаад албан ажлаар, төрийн зардлаар ажиллах Төрийн албан хаагчид хуулийн хугацаанд аймгаас зөвшөөрөл авах, ирсэн даруйд 5 хоногт багтаан илтгэх | - | Хэрэгжилт | - | Хэрэгжүүлж ажилласан байна. | Аймгийн Засаг даргын ОХУ-д хийсэн албан айлчлалын бүрэлдэхүүнд ажилласан 1 удирдах албан тушаалтан хугацаанд нь тайлагнасан. | 100% |
| 5.1.4 | Засгийн газрын 2021 оны 226 дугаар тогтоолоор баталсан тамга, тэмдэг баталгааны тэмдэг хийлгэх, хэрэглэх, зарцуулах журмын хэрэгжилтйг хангуулах | - | Хэрэгжилт | - | Хэвлэмэл хуудасны зарцуулалтын тайлан мэдээг хагас бүтэн жилээр тайлагнасан байна. | Журмын дагуу хийлгэсэн тамга тэмдэг хэрэглэж байна. Хэвлэмэл хуудасны зарцуулалтын тайлан мэдээг жилийн эцсийн байдлаар гарган АЗДТГ-ын Архивын тасагт хүргүүлсэн. | 100% |
| 5.1.5 | Монгол бичгийн хэвлэмэл хуудсаа хэвлүүлж, хэрэглэж хэвших, Монгол бичгийн хэвлэмэл хуудас дээр албан бичгээ монгол бичгээр сийрүүлж компьютерт шивж сурах | - | Хэрэгжилт | - | Арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан байна. Албан хаагчдын Үндэсний бичгийн мэдлэг чадвар сайжирч, компьютерт шивж сурсан байх | 2 ажилтан Удирдлагын Академиас зохион байгуулсан цахим сургалтад хамрагдаж Сертификат авсан. 5 ажилтны компьютерт Монгол бичгийн фондыг суулгалаа. Насан туршийн боловсролын төвтэй хамтран ажиллагсдыг 20 цагийн сургалтад хамруулсан. Байгууллагын хэвлэмэл хуудсын эхийг Монгол бичгээр гаргаж хэвлүүлэх зөвшөөрөл авахаар байгууллагын 10 дугаар сарын 14-ны өдрийн 01/314 албан бичгээр Аймгийн Архивын тасагт хүргүүлсэн. | 100% |
| 5.1.6 | Байгууллагын албан хаагчдад “Баримт бичиг зохион бүрдүүлэх арга зүй, баримт бичгийн стандарт”-аар Архивын ерөнхий газраас мэргэжилтэн урьж сургалт зохион байгуулан, | - | Хэрэгжилт | - | Албан хаагчдын албан бичиг хэрэг хөтлөлтийн мэдлэг чадварыг нэмэгдүүлсэн байна. | Архив бичиг хэргийн ажилтан Архивын Ерөнхий газраас зохион байгуулсан сургалтад хамрагдаж Мэргэжлийн үнэмлэх авсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэргэжил арга зүйн зөвлөгөө авах | | | | | | |
| 5.1.7 | Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем ERP-г бүрэн нэвтрүүлж албан хаагчдыг хамруулах | - | Хэрэгжилт | - | Байгууллагын үйл ажиллагаандаа ERP-системийг ашиглаж хэвшсэн байна. | Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн ERP системд шинээр орсон болон чөлөөлөгдсөн албан хаагчдын бүртгэл, байгууллагын мэдээллийг тухай бүр шинэчилсэн. 2024 онд ERP системээр 152 албан бичиг хүлээн авч, 26 албан бичиг хүргүүлсэн байна. Байгууллагын албан хаагчид дотоод үйл ажиллагаандаа тогтмол хэрэглэж хэвшсэн. | 100% |
| 5.1.8 | УИХ-ын 2023 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг байгууллагын хэмжээнд зохион байгуулж тайлагнах | - | Хэрэгжилтийн хувь | - | “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг байгууллагын хэмжээнд зохион байгуулж тайлагнана. | 2024 оны 01 сарын 19 өдрийн Соёл урлагийн газрын даргаар батлуулсан Авлигаас урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг 100 хувьтай биелүүлсэн. Тус төлөвлөгөөний хүрээнд АТГ-с зохион байгуулсан 2 удаагийн цахим сургалтад 6 албан хаагч хамрагдсан. Байгууллагын мэдээллийн самбар, цахим хаягт Авлигаас урьдчилан сэргийлэх шторк, зурагт хуудсыг байршуулсан. | 100% |
| **5.4 Нийгмийн бодлогын хэлтсийн чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ** | | | | | | | |
| 5.4.1 | “Хүн амын бие бялдарын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох, сорил”-д байгууллагын албан хаагчдыг хамруулах | - | Хамрагдсан албан хаагчдын тоо | | Албан хаагчдыг бүрэн хамруулсан байна. | “Хүн амын бие бялдарын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох, сорил”-д албан хаагчдыг бүрэн хамруулсан. | 100% |
| **5 зорилт 86 арга хэмжээ Дундаж 98.1%** | | | | | | | |

ТАНИЛЦСАН: ХЯНАСАН: БОЛОВСРУУЛСАН:

ДАРГА Г.АЛДАРМӨНХ Соёл урлагийн хэлтсийн дарга /Д.Баасанжав/ ТТМТЦАХАМэргэжилтэн /Г.Лхагвадаш/